



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар E/08

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Малын гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Зохих журмын дагуу хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ

2024000039



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай-6,
Утас: 26-30-83, Факс: 26-12-73
E-mail: Office@president.mn

2024.05.16 № 717369
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Д.ЭНХБАТ ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацаа товлох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Малын гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж, өргөн мэдүүлэхэд бэлэн болоод байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу тогтоолын төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Тогтоолын төслийг холбогдох материалын хамт хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Я.СОДБААТАР

2024000501

БАТЛАВ:

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**



**“МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙН БОЛОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 3.5-д “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 4.2.2-т “хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” гэж, 4.5.1-д “судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан, гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.9-д “Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 1.15 дахь хэсгийн 139-д Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулахаар тус тус заасан.

Хөнгөн үйлдвэрлэлийн салбарт хамаарах Хөрөнгө оруулалтын тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай, Хөдөө аж ахуйн биржийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай зэрэг хууль үйлчилж байгаа хэдий ч хөнгөн үйлдвэрийн тулгамдсан асуудлыг төрийн бодлогоор дэмжих шалгуур, ангилал, арга хэлбэрийг дээрх хуулиудаар тусгайлан зохицуулаагүй байна.

1.2.Практик шаардлага

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2022 онд 43.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 8.6 (24.4 хувиар) их наяд төгрөгөөр, 2018 оноос 16.3 (59.7%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Үүнд боловсруулах үйлдвэрлэлийн салбар 2.8 (25.6%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хөнгөн үйлдвэрлэлийн салбар 2023 онд нийтдээ 484.8 сая ам долларын экспорт хийсний 93 хувь буюу 451.2 сая ам долларыг нэхмэлийн буюу ноос, ноолуурын салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

Манай улс дэлхийн ноолуурын нөөцийн 40 гаруй хувийг бэлтгэх нөөцтэй хэдий ч нэмүү өртөг бүтээх, өндөр ашиг шим хүртэх стратегийн бүтээгдэхүүнээсээ олох боломжит орлогоо алдсаар байна.

Манай улс Дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүргийн дагуу экспортод гаргах түүхий болон угаасан ноолуур экспортын татварыг шатлан халсан холбоотойгоор угаасан ноолуурын экспорт 1997 онтой харьцуулбал 6.6 дахин өссөн байна.

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд байгуулсан ноос, ноолуур экспортлох үеийн мал эмнэлэг, ариун цэвэр хорио цээрийн протоколын хүрээнд манай улсаас тус улсад түүхий бус угаасан ноос, ноолуур экспортлох болсноор манай улс жилд дунджаар 1.2 сая м3 цэвэр усыг ашиглаж, төдий хэмжээний бохир усыг байгаль орчинд гаргаж, дорвитой нэмүү өртөг шингээж чадахгүйгээр нийт түүхий эдийнхээ 70 гаруй хувийг зөвхөн угаагаад тус улсад экспортолсоор байна.

Манай улс жилдээ 18 сая ширхэг арьс, шир бэлтгэх нөөцтэй хэдий ч өнөөгийн байдлаар арьс ширний нөөцийн 30 хүрэхгүй хувийг үндэсний боловсруулах үйлдвэрт нийлүүлэгдэж байна. Тухайлбал жилд 3.4 сая ширхэг арьс ширэнд хагас боловсруулалт, 1.2 сая ширхэг арьс ширэн гүн боловсруулалт, нийт 4.6 сая ширхэг нь боловсруулагдаж, 13.4 сая ширхэг арьс ширийг боловсруулж чадахгүй байна.

Сүүлийн жилүүдэд үндэсний боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эд бэлтгэлд зориулан хөнгөлөлттэй зээл олгож байгаа боловч банкны шалгуур өндөр, барьцаа хөрөнгийн дутагдалтай байдал, эргэн төлөлтийн хугацаа бага зэргээс шалтгаалан хангалттай хэмжээний зээлээ авч чадахгүй байна.

Нөгөөтээгүүр хөрөнгө оруулалтын чиглэлээр бага хүүтэй, урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл гарахгүй байгаагаас шалтгаалан дэвшилтэт технологи бүхий, шинэ тоног төхөөрөмжийг худалдан авч чадахгүйгээс хуучин тоног төхөөрөмж оруулж ирэх явдал түгээмэл байна. Үйлдвэрлэлийн бүтээмж бага, хүчин чадлын ашиглалт доогуур, өртөг зардал өндөр байдгаас ижил төрлийн импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөж чадахгүй байна.

Энэ нь үйлдвэрлэл дорвитой хөгжихгүй байхад нөлөөлж байна.

Манай улс чөлөөт зах зээлд шилжсэнээс хойш түүхий эд бэлтгэлийн тогтолцоо бүхэлдээ байхгүй болсон нь түүхий эд үнэгүйдэх, мал аж ахуй эрхлэгчдийн бэлтгэж буй түүхий эд нь үйлдвэрлэлийн шаардлага хангахгүй байдлыг үүсгэж байна.

Үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах зорилгоор хонь, тэмээний ноос, арьс, ширэн түүхий эд бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгож эхлээд 10 гаруй жил болж байгаа хэдий ч түүхий эдийн чанар сайжирч, үнэ цэнэ нь өсөхгүй байгаад дүгнэлт хийж, урамшууллын бодлогыг зөв, оновчтой зүйлд чиглүүлэх шаардлагатай байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 2021 оны судалгаанаас үзвэл бог малын арьсанд хачиг, хамууны гэмтэл үүнээс гадна шивээний гэмтэл, харин адууны ширэнд тамганы сорви их байсан байна.

Иймд бог малыг бүрэн эрүүлжүүлэх, мал сүргийнхээ арьсанд механик гэмтэл үүсгэхгүй байх талаар малчдад сургалт хийх шаардлагатай байна.

Түүнчлэн 2025 оноос хэрэгжиж эхлэх махны техникийн зохицуулалттай уялдуулан мал төхөөрөх үйлдвэрүүд, арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг сайжруулах замаар арьс ширний нядалгааны үеийн гэмтлийг бууруулах боломжтой юм.

Мөн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн шаардлагыг хангасан байх, нийлүүлэлт хийх зорилтот зах зээл нь тодорхой байх нь нэн чухал байдаг. Гэтэл ижил нэрийн барааны импорт болон худалдааны хяналтын тогтолцоо бэхжээгүй байгаагаас дотоодын зах зээл хамгаалагдахгүйд хүрч улмаар нэг талаас хэрэглэгчдийг төөрөгдүүлж, иргэд эдийн засгийн хувьд хохирч байгаа бол нөгөө талаас энэ байдал нь үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд ч саад болж байна.

Иймээс үнэ цэнэ шингэсэн, өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үйл явцыг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн баталгаажуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд гаднын томоохон худалдан авагчид түүхий эд бүтээгдэхүүнийг худалдан авахдаа чанар, түүнээс гадна байгаль орчинд ээлтэй байх, мал, амьтны тавлаг байдлыг хангасан байх гэдэг шаардлагыг ихээхэн тавьдаг болсон.

Эрс, тэс уур амьсгалтай, бэлчээрийн мал аж ахуйгаа хадгалан үлдсэн манай улсын хувьд өөрийн орны онцлог соёл, монгол малчдын байгаль орчин, мал ахуйгаа хайрлан хамгаалж, уламжлан ирсэн өвөрмөц арга ажиллагааг орчин цагийн органик үйлдвэрлэл, мал, амьтны эрх чөлөөний нийтлэг зарчимтай уялдуулан тэдний шаардлагад нийцсэн үнэ цэнэтэй, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлээ тэлэх шаардлагатай байна.

Түүнчлэн хөнгөн үйлдвэрийн бүх салбарт мэргэшсэн инженер, техникийн ажилтнууд болон мэргэжилтэй ажилчин бэлтгэх тогтолцоо төлөвшөөгүй, ажиллах хүчний тогтвор суурьшил муу байна.

Ноос, ноолуурын үйлдвэрүүдэд 2020 онд хийсэн аттестатчиллаар төгсөгчдийн тоог үйлдвэрлэлийн хүчин чадалд шаардагдах эрэлттэй харьцуулахад хангалтгүй байсан, үйлдвэрийн цех тасгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж буй мастерууд нь мэргэжлийн бус байгааг онцолсон байна.

Хүний нөөц дутагдалтай байгаа нь салбарын ажилтны цалингийн дундаж бусад салбар тухайлбал, уул уурхайн салбарт ажиллаж буй ажилтнуудтай харьцуулахад бага байгаатай холбоотой юм. Хүний нөөцийг сургах, тогтвор суурьшилтай ажиллахад түлхэц болох цалин хөлс, урамшууллын шинэлэг арга, аргачлалыг ашиглах,

бүтээгдэхүүний чанартай уялдуулсан системийг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, урамшуулах тогтолцоо дутмаг байна.

Нөгөөтээгүүр шинээр батлагдсан зарим хууль тогтоомжийг дагаад хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжилд чухал нөлөө үзүүлж байсан хөнгөн үйлдвэрийн салбарын мэргэшсэн, зөвлөх, тэргүүлэх инженерүүдийг сурган баталгаажуулж, гэрчилгээжүүлэх зохицуулалт орхигдсон нь тус салбарын тулгамдсан асуудлыг улам нэмэгдүүлсээр байна.

Эдгээр тулгамдаж буй асуудал нь өөр хоорондоо харилцан уялдаатай байх бөгөөд нэгийг нь шийдвэрлэснээр үр дүн гарах бус цогцоор шийдвэрлэх нь зүйтэй байна.

Дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагыг үндэслэн мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор “Малын гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор батлахаар, малыг эрүүлжүүлэх, арьс ширний чанарыг сайжруулах, түүхий эдийн бэлтгэл, урамшууллын оновчтой тогтолцоог бий болгох, малын гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчин бүрдүүлэх, чанар, стандартын шаардлага хангасан түүхий эд бүтээгдэхүүнийг баталгаажуулах, олон улсад магадлан итгэмжлүүлэх, сурталчлан таниулах, үйлдвэрлэлийг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан цогцолбор, кластер байдлаар хөгжүүлэх, хүний нөөцийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжих чиглэлээр хууль эрх зүйн орчныг сайжруулах, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд тус тус даалгахаар, бусад шаардлагатай арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар, тогтоолын хэрэгжилтэд хяналтад тавьж, үр дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулахыг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд даалгахаар, түүнчлэн дагаж мөрдөх хугацааны талаарх зохицуулалтыг тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Тогтоолын төсөл батлагдсанаар нийгэмд ямар нэгэн сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд олон улсын стандартад нийцсэн өрсөлдөх чадвартай, гарал үүсэл, чанарын баталгаатай, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт нэмэгдэж, малын гаралтай түүхий эдийн үнэ цэнэ сайжрах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд

шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хуультай нийцсэн байх бөгөөд Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийг шинээр боловсруулж, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж, үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчинг бүрдүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Монгол Улсын Их Хурлын “Үндэсний үйлдвэрлэгчдийн дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 2011 оны 30 дугаар тогтоолын 1.1 дэх заалт, “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийн дэмжих зарим арга хэмжээний тухай” 2012 оны 4 дүгээр тогтоолын 2.1 дэх заалтыг хүчингүй болгохтой холбогдох тогтоолын төслийг тус тус боловсруулна.

---xXx---

“МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогод боловсруулах үйлдвэрлэл, тэр дундаас мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг байгальд ээлтэй байдлаар хөгжүүлэх, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркийг нийлүүлэлтийн сүлжээний хамт үе шаттайгаар байгуулах зорилтууд тусгагдсан.

Манай улс жилд дунджаар 49.8 мянган тонн ноос, ноолууран түүхий эд бэлтгэх нөөцтэй байна. Үүнээс хонины ноос 37.0 мянган тонн, ямааны ноолуур 10.0 мянган тонн, тэмээний ноос 2.0 мянган тонн, сарлагийн хөөвөр 400 тонн байна. Ноос, ноолууран түүхий эдийнхээ 70 гаруй хувийг нь зөвхөн угаагаад экспортолж байна.

Монгол улс 2023 оны эцэст 64.6 сая толгой мал тоолуулсан бол энэ жилийн өвөлжилт, хаваржилтын хүндрэлтэй байдлаас шалтгаалан 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар 6.9 сая толгой мал, үүнээс 0.003 сая тэмээ, 0.38 сая адуу, 0.6 сая үхэр, 3.7 сая толгой хонь, 2.3 сая толгой ямаа тус тус хорогдоод байна. Эндээс тооцоход хонины ноосны нөөц 31.6 мян.тонн, ямааны ноолуур 8.0 мян.тонн болж буурахаар байна.

Уул уурхайн бус экспортын гол бүтээгдэхүүн ноос, ноолуурын боловсруулалтын түвшинг үе шаттай ахиулж дотооддоо бүрэн боловсруулснаар нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

Арьс, ширний салбарын хувьд авч үзвэл жилд дунджаар 18 сая ширхэг арьс, ширэн түүхий эд нөөц бэлтгэх нөөцтэй хэдий ч, 30 хүрэхгүй хувийг нь боловсруулж, үлдсэн хувийг нь боловсруулж чадахгүй байна. Тухайлбал дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд 2023 онд 3.3 сая ширхэг арьс ширэнд хагас боловсруулалт, 2.3 сая ширхэг арьс ширэн гүн боловсруулалт, нийт 5.5 сая ширхэг нь боловсруулж, 12.5 сая ширхэг арьс ширийг боловсруулж чадаагүй байна.

Арьс, шир боловсруулах салбарт нийт 14.9 сая ширхэг арьс ширийг хагас боловсруулах, 700 мянган ширхэг бодын шир, 1.7 сая ширхэг богийн арьс ширийг гүн боловсруулах хүчин чадал суурилагдсан ба арьс ширний гүн боловсруулалтын хүчин чадал дутагдалтай байна.

Дотоодын боловсруулах үйлдвэрүүдийн хөрөнгийн чадавх сул, арилжааны банкны зээлийн хүү, барьцаа хөрөнгийн шаардлага өндөр, түүхий эдийн зах зээлд гаднын худалдан авагчдын өрсөлдөөн их, түүхий эдийн чанар муу, бэлтгэлийн оновчтой тогтолцоо хөгжөөгүй, хууль эрх зүйн орчин дутагдалтай зэргээс шалтгаалан түүхий эдээ дотооддоо бүрэн боловсруулж чадахгүй, боломжит орлогоо алдсаар байна.

Түүнчлэн үйлдвэрүүдэд нарийн мэргэжлийн хүний нөөц, инженер, техникийн ажилтны хангамж дутмаг, тогтвор суурьшил сул байна. Үйлдвэрүүд хүний нөөцийг сургах, тогтвор суурьшилтай ажиллуулахад боломжоороо анхаарч байгаа хэдий ч цөөн хэдэн үйлдвэрээс бусад нь хүний нөөцийн дутагдалтай байна.

Дэлхийн зах зээлд 2023 оны байдлаар 652.9 тэрбум ам.долларын хувцасны хэрэгцээ байна. Энэ нь 2027 онд 830.7 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байгаагаас 2 хувийг ноос, ноолууран хувцас эзэлж байна. Мөн дэлхий нийтийн чиг хандлага байгальд ээлтэй үйлдвэрлэлд анхаарах болж, эко бүтээгдэхүүний хэрэглээ 2032 онд 2 дахин нэмэгдэх төлөвтэй байна.

Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлого, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дэлхийн зах зээлийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлага, түүхий эдийн нөөцөд тулгуурлан “Цагаан алт” болсон малын гаралтай түүхий эдээ бүрэн ашиглаж, үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүн болгох, дотооддоо нэмүү өртөг бүтээх шаардлагатай байна.

Иймд дээр дурдсан тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан “Цагаан алт” хөдөлгөөнийг өрнүүлэх хүрээнд “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор батлахаар, малыг эрүүлжүүлэх, арьс ширний чанарыг сайжруулах, түүхий эдийн бэлтгэл, урамшууллын оновчтой тогтолцоог бий болгох, малын гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчин бүрдүүлэх, чанар, стандартын шаардлага хангасан түүхий эд бүтээгдэхүүнийг баталгаажуулах, олон улсад магадлан итгэмжлүүлэх, сурталчлан таниулах, үйлдвэрлэлийг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан цогцолбор, кластер байдлаар хөгжүүлэх, хүний нөөцийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжих чиглэлээр хууль эрх зүйн орчныг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хөнгөн аж үйлдвэрийг дэмжих “Цагаан алт” хөдөлгөөний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, хүрэх үр дүнгийн талаарх хэлэлцүүлгийг Монголын ноос ноолуурын холбоо, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, салбарын үйлдвэрлэгчид, их дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагууд, хоршооны төлөөллийг оролцуулан зохион байгуулж, Улсын Их Хурлын тогтоолын төсөлд дэвшүүлсэн саналуудыг нэгтгэн тусгасан болно.

Тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан журмын дагуу Засгийн газарт хүргүүлж санал авсан бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурдагдсан асуудлыг хүлээн авч төсөлд тусгасан болно.

Түүнчлэн Тогтоолын төслийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын цахим хуудсанд байршуулан иргэд, олон нийтийн саналыг авсан бөгөөд санал ирүүлээгүй болно.

--- x X x ---

**“МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ
ДЭМЖИХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно” гэж, 4.5.1-д “судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан, гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 3.5-д “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 4.2.2-т “хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.9-д “Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ” гэсэн зорилтууд тусгагдсан.

Манай улс жилд дунджаар 49.8 мянган тонн ноос, ноолууран түүхий эд бэлтгэх нөөцтэй байна. Үүнээс хонины ноос 37.0 мянган тонн, ямааны ноолуур 10.0 мянган тонн, тэмээний ноос 2.0 мянган тонн, сарлагийн хөөвөр 400 тонн байна. Ноос, ноолууран түүхий эдийнхээ 70 гаруй хувийг нь зөвхөн угаагаад экспортолж байна.

Монгол улс 2023 оны эцэст 64.6 сая толгой мал тоолуулсан бол энэ жилийн өвөлжилт, хаваржилтын хүндрэлтэй байдлаас шалтгаалан 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар 6.9 сая толгой мал, үүнээс 0.003 сая тэмээ, 0.38 сая адуу, 0.6 сая үхэр, 3.7 сая толгой хонь, 2.3 сая толгой ямаа тус тус хорогдоод байна. Эндээс тооцоход хонины ноосны нөөц 31.6 мян.тонн, ямааны ноолуур 8.0 мян.тонн болж буурахаар байна.

Арьс, ширний салбарын хувьд авч үзвэл жилд дунджаар 18 сая ширхэг арьс, ширэн түүхий эд нөөц бэлтгэх нөөцтэй хэдий ч, 30 хүрэхгүй хувийг нь боловсруулж, үлдсэн хувийг нь боловсруулж чадахгүй байна. Тухайлбал дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд 2023 онд 3.3 сая ширхэг арьс ширэнд хагас боловсруулалт, 2.3 сая ширхэг арьс ширэн гүн боловсруулалт, нийт 5.5 сая ширхэг нь боловсруулж, 12.5 сая ширхэг арьс ширийг боловсруулж чадаагүй байна.

Арьс, шир боловсруулах салбарт нийт 14.9 сая ширхэг арьс ширийг хагас боловсруулах, 700 мянган ширхэг бодын шир, 1.7 сая ширхэг богийн арьс ширийг гүн боловсруулах хүчин чадал суурилагдсан ба арьс ширний гүн боловсруулалтын хүчин чадал дутагдалтай байна.

Дотоодын боловсруулах үйлдвэрүүдийн хөрөнгийн чадавх сул, арилжааны банкны зээлийн хүү, барьцаа хөрөнгийн шаардлага өндөр, түүхий эдийн зах зээлд гаднын худалдан авагчдын өрсөлдөөн их, түүхий эдийн чанар муу, бэлтгэлийн оновчтой тогтолцоо хөгжөөгүй, хууль эрх зүйн орчин дутагдалтай зэргээс

шалтгаалан түүхий эдээ дотооддоо бүрэн боловсруулж чадахгүй, боломжит орлогоо алдсаар байна.

Уул уурхайн бус экспортын гол бүтээгдэхүүн ноос, ноолуурын боловсруулалтын түвшинг үе шаттай ахиулж дотооддоо бүрэн боловсруулснаар нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

Түүнчлэн үйлдвэрүүдэд нарийн мэргэжлийн хүний нөөц, инженер, техникийн ажилтны хангамж дутмаг, тогтвор суурьшил сул байна. Үйлдвэрүүд хүний нөөцийг сургах, тогтвор суурьшилтай ажиллуулахад боломжоороо анхаарч байгаа хэдий ч цөөн хэдэн үйлдвэрээс бусад нь хүний нөөцийн дутагдалтай байна.

Дэлхийн зах зээлд 2023 оны байдлаар 652.9 тэрбум ам.долларын хувцасны хэрэгцээ байна. Энэ нь 2027 онд 830.7 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байгаагаас 2 хувийг ноос, ноолууран хувцас эзэлж байна. Мөн дэлхий нийтийн чиг хандлага байгальд ээлтэй үйлдвэрлэлд анхаарах болж, эко бүтээгдэхүүний хэрэглээ 2032 онд 2 дахин нэмэгдэх төлөвтэй байна.

Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлого, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дэлхийн зах зээлийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлага, түүхий эдийн нөөцөд тулгуурлан "Цагаан алт" болсон малын гаралтай түүхий эдээ бүрэн ашиглаж, үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүн болгох, дотооддоо нэмүү өртөг бүтээх шаардлагатай байна.

Иймд дээр дурдсан тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан "Цагаан алт" хөдөлгөөнийг өрнүүлэх хүрээнд "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөл нь 4 зүйлтэй бөгөөд төсөлд дараах асуудлыг тусгав. Үүнд:

Нэг. "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай." гэж тусгав.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор батлахаар, малыг эрүүлжүүлэх, арьс ширний чанарыг сайжруулах, түүхий эдийн бэлтгэл, урамшууллын оновчтой тогтолцоог бий болгох, малын гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчин бүрдүүлэх, чанар, стандартын шаардлага хангасан түүхий эд бүтээгдэхүүнийг баталгаажуулах, олон улсад магадлан итгэмжлүүлэх, сурталчлан таниулах, үйлдвэрлэлийг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан цогцолбор, кластер байдлаар хөгжүүлэх, хүний нөөцийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжих чиглэлээр хууль эрх зүйн орчныг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Хоёр. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих "Цагаан алт" хөдөлгөөнийг өрнүүлж, дараах арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай" гэж тусгав.

Салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр 6, түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтоолцоог дэмжих чиглэлээр 6, үйлдвэрлэл, борлуулалт, экспортыг

нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх чиглэлээр 8, салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, дэмжих чиглэлээр 5 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан.

Гурав. “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн санхүүжилтийг “Цагаан алт” хөдөлгөөний хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээтэй уялдуулан ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосугай.” гэж тусгав.

Сүүлийн жилүүдэд үндэсний боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эд бэлтгэлд зориулан хөнгөлөлттэй зээл олгож байгаа боловч банкны шалгуур өндөр, барьцаа хөрөнгийн дутагдалтай байдал, эргэн төлөлтийн хугацаа бага зэргээс шалтгаалан хангалттай хэмжээний зээлээ авч чадахгүй байгаа тул гадаадын зээл, тусламжийг “Цагаан алт” хөтөлбөртэй уялдуулан шийдвэрлэхээр тусгасан.

Дөрөв. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг жил бүрийн хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлж, хэрэгжилт, үр дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай” гэж тусгав.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу урьдчилсан байдлаар тооцож тусгасан.

Тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан журмын дагуу Засгийн газарт хүргүүлж санал авсан бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд дурдагдсан асуудлыг хүлээн авч төсөлд тусгасан болно.

Түүнчлэн тогтоолын төслийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын цахим хуудсанд байршуулан иргэд, олон нийтийн саналыг авсан ба “Цагаан алт” хөдөлгөөний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, хүрэх үр дүнгийн талаарх хэлэлцүүлгийг Монголын ноос ноолуурын холбоо, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, салбарын үйлдвэрлэгчид, их дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагууд, хоршооны төлөөллийг оролцуулан зохион байгуулж, Улсын Их Хурлын тогтоолын төсөлд дэвшүүлсэн саналуудыг нэгтгэн тусгасан болно.

Тогтоолын төсөл батлагдсанаар нийгэмд ямар нэгэн сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд олон улсын стандартад нийцсэн өрсөлдөх чадвартай, гарал үүсэл, чанарын баталгаатай, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт нэмэгдэж, малын гаралтай түүхий эдийн үнэ цэнэ сайжрах эрх зүйн орчин бүрдэнэ.

--- х Х х ---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих "Цагаан алт" хөдөлгөөнийг өрнүүлж, дараах арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр

а/хөнгөн үйлдвэрлэлд хамаарах салбар, оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих, хөгжүүлэх, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

б/үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх татвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчинг бүрдүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2024 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

в/малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хууль эрхзүйн таатай орчин бүрдүүлэх;

г/хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

д/малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд хэрэгжүүлж байгаа урамшууллыг дүгнэж, үр дүнд суурилсан, зах зээлийн зарчимд нийцүүлэхэд чиглүүлэх;

е/дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг ахиулахтай холбоотой зайлшгүй шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг батлан хэрэгжүүлэх;

2/Түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог дэмжих чиглэлээр

а/малыг эрүүлжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт технологи бүхий дотоодын вакцин үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, мал вакцинжуулах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, тогтолцоог сайжруулах;

б/улсын болон аймгийн мал эмнэлэг, ариун цэврийн лабораториудын үйл ажиллагааг уялдуулан, стандартын шаардлага хангасан өндөр хүчин чадалтай бүсийн мал эмнэлгийн лабораториудыг байгуулж, орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах;

в/бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд суурилсан хөдөө аж ахуйн тэргүүлэх бүсүүдэд дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын тайван бүсийн үзүүлэлтүүдийг тогтоож, тогтвортой хадгалах;

г/малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр дамжуулан арилжаалах, түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалтыг бий болгох замаар нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх;

д/түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцооны цахим санг хөгжүүлж, гарал үүсэл, чанар нь баталгаажсан түүхий эдийг үндэсний үйлдвэрт нийлүүлэх, экспортод гаргахыг дэмжих;

е/түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийг стандартын дагуу түүхий эд бэлтгэхэд чадавхжуулах, мэргэшүүлэх.

3/үйлдвэрлэлт, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх чиглэлээр:

а/түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд татвар, зээлийн хүүгийн бодлогоор дэмжлэг үзүүлэх;

б/олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг бүсийн онцлогт тулгуурласан үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахад чиглүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгийг улсын төсөв тусган хэрэгжүүлэх;

в/эцсийн бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэхэд чиглэсэн бодлогоор дэмжиж, үндэсний үйлдвэрүүдийг олон улсын томоохон үзэсгэлэнгүүдэд тогтмол оролцоход дэмжлэг үзүүлэх,

г/байгаль орчин, мал амьтанд ээлтэй, тохирлын баталгаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үйл явцыг баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх;

д/нэмүү өртөг шингэсэн, байгаль орчинд ээлтэй шинэ, дэвшилтэд технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, байгаль орчинд эерэг нөлөөтэй, зохистой дадал, стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийг ногоон санхүүжилтэд хамруулах, арга туршлагыг нийтэд таниулах арга хэмжээг зохион байгуулах;

е/үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэлт, байгаль орчинд ээлтэй тогтолцооны болон зохистой дадлын стандартын хэрэгжүүлэлт, баталгаажуулалт зэрэг үйлдвэрлэлийн хөгжил дэвшлийн талаар мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах;

ж/“Цагаан алт” хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжилтийг түүхий эдийн нөөцийн зохистой харьцааг хангасан нэмүү өртөг бий болгох үйлдвэрлэлд түлхүү чиглүүлэх;

з/Малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг газар зүйн заалтаар тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Монгол Улсад бүртгэгдсэн газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүнийг гадаад улсын газар зүйн заалтад бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх.

4/Салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, дэмжих чиглэлээр:

а/үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт (YAMAT-08) болон сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг салбарын холбоодтой хамтран зохион байгуулах;

б/гадаадын өндөр хөгжилтэй оронд инженер техникийн ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, “Ерөнхийлөгчийн илгээлт 2100” хөтөлбөрт хамруулах;

в/бүсийн үйлдвэрлэлийн чиглэлтэй уялдуулан салбарын хүний нөөцийг коллеж болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд сургах, нарийн мэргэжлийн ажилтнуудыг гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежид бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх;

г/Улаанбаатар хотоос орон нутагт хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллахаар шилжин суурьшиж байгаа иргэдийг тогтвортой ажиллах нөхцөлөөр хангах;

д/үндэсний ажил мэргэжлийн стандарт ба цалин хөлсний бодлогыг боловсруулах, ажилтнуудын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, хүн төвтэй зохистой хөдөлмөрийн харилцааг төлөвшүүлэх Тарифын хэлэлцээр боловсруулах, хэрэгжүүлэх.

3.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн санхүүжилтийг “Цагаан алт” хөдөлгөөний хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээтэй уялдуулан ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг жил бүрийн хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлж, хэрэгжилт, үр дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Ж.Батжаргал/, Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Г.Ганболд/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд тус тус даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2024 оны дугаар сарын-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ... дүгээр сарын -ны өдрийн дугаар тогтоолын хавсралт

"МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2023/	Хүрэх түвшин	Нийт санхүүжилт /сая төг/	Санхүүжилт ийн эх үүсвэр	Санхүүжилтийн хуваарь /сая төг/					Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа, оноор
								2024 он	2025 он	2026 он	2027 он	2028 он		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1.1.1	1.1. Хөнгөн үйлдвэрлэлд хамаарах салбар, оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих, хөгжүүлэх, хамтаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит болон 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг дэмжсэн, суурь харилцааг зохицуулсан "Хөнгөн үйлдвэрлэлийн тухай" хуулийн төслийг шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Хуулийн төсөл боловсруулсан байх	Хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг дэмжсэн, суурь харилцааг зохицуулсан тусгайлан хууль байхгүй.	Хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.	50.0	Улсын төсөв	50.0	-	-	-	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024
1.1.2		Ижил нэр төрлийн бүтээгдэхүүний импортын гаалийн татварыг үе шаттайгаар нэмэгдүүлэх	Засгийн газрын 2016 оны 185 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын төсөл боловсруулах	Засгийн газрын 2016 оны 185 дугаар тогтоолоор ноос, ноолуур, арьс ширэн зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортын гаалийн татварын зарим нэр төрлийн хэмжээг "20 хувь" хэртэл нэмэгдүүлэхтэй холбогдох Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, баталсан байна.	Ноолуур, арьс ширэн зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортын гаалийн татварын зарим нэр төрлийн хэмжээг "20 хувь" хэртэл нэмэгдүүлэхтэй холбогдох Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, баталсан байна.	-	-	-	-	-	-	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Сангийн яам	2028
1.2.3		Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн барьсан байх	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль-2011 он	Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэн байна.	-	-	-	-	-	-	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2025

1.2.4	Дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, түүхий эдийн боловсруулалтын ахиулахтай холбоотой зайлшгүй шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг батлан хэрэгжүүлэх	Стандарт, техникийн зохицуулалтын төслийг боловсруулах	Техникийн зохицуулалт-1 Олон улсын стандарт-0	Техникийн зохицуулалт-2 Олон улсын стандарт-1	180.0	Улсын төсөө, Гадаадын зээл тусламж	60.0	60.0	60.0	-	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, олон улсын төсөл, хөтөлбөр	2024-2026
	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын таатай орчныг бий болгохтой холбогдох хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах	-	Хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.								Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024
		Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах	-	Хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.								Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024
		Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах	-	Хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.								Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024
		Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах		Хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.								Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024
1	Дүн				230.0	-	110.0	60.0	60.0	-	-		
Хоёр. Түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог дэмжих чиглэлээр													
2.1	2.1.Малыг эрүүлжүүлэх, түүхий эдийн чанарыг сайжруулахтай холбогдуулан малын эм үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Биокомбинат ТӨХХ-ийн өргөтгөл шинэчлэлийг хийх	Вакцины хангамжийн хувь	80 хувь	100 хувь (Импортөөр авч байгаа 7.5 сая ам долларын вакциныг дотооддоо үйлдвэрлэнэ.)	129,300.0	Улсын төсөө, гадаадын зээл тусламж	43,100.0	43,100.0	43,100.0	-	Мал эмнэлгийн ерөнхий газар, "Биокомбина-т" ТӨХХК	2024-2027

2.2.1	2.2.Мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, шинжилгээний чадавхыг сайжруулах	Улсын болон аймгийн мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн үйл ажиллагааг уялдуулан, стандартын шаардлага хангасан өндөр хүчин чадалтай бүсийн мал эмнэлгийн лабораторийг байгуулж, орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах	Олон Улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжилгээний арга нэвтрүүлэлтийн тоо	3	8	30,000.0	Улсын төсөв	-	10,000.0	8,000.0	8,000.0	4,000.0	Мал эмнэлгийн ерөнхий газар, Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар	2024-2027
2.3	2.3. Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийг биржээр дамжуулан борлуулах түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалтыг хийх	Хөдөө аж ахуйн биржийн худалдааг зах зээлийн зохион байгуулалтад оруулах, түүхий эдийн чанар, стандартыг сайжруулах, хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо нэвтрүүлэх	Хөдөө аж ахуйн биржийн цогц систем	0	1	5,000.0	Гадаадын зээл, тусламж	-	1,600.0	1,600.0	1,800.0	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Аймаг, сумын Засаг даргын таамгын газар, Олон улсын төсөл, хөтөлбөр	2024-2028
2.4.1	2.4.Малын гаралтай түүхий эдийн гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцоог дэмжих	Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэл, гарал чанар, гарал үүслийг мөшгөх цахим бүртгэлийн системийг бий болгож, хөгжүүлэх	Малын гаралтай түүхий эдийн бэлтгэл, гарал үүслийн мөшгөх бүртгэлийн систем бий болгох	Мал аж ахуйн нэгдсэн систем, Мал эмнэлгийн нэгдсэн систем, "Хариуцлагатай нүүдэлчин" цахим систем хөгжүүлсэн. Махны гарал үүслийн мөшгөх цахим бүртгэлийн системийг бий болгож байна.	Малын гаралтай түүхий эдийн бэлтгэл, гарал үүслийн мөшгөх бүртгэлийн систем бий болсон байна.	380.0	Гадаадын зээл, тусламж	85.0	80.0	75.0	60.0		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024-2028
2.4.2		Түүхий эдийн бэлтгэл, чанар, гарал үүслийн мөшгөх цахим бүртгэлийн системийг нэвтрүүлэх	Цахим бүртгэлийн системийг нэвтрүүлсэн байх	Махны 2 үйлдвэр дээр мөшгөх цахим бүртгэлийн системийг нэвтрүүлээд байна.	Ноос, ноолуур, арьс ширний бүртгэл, чанар, гарал үүслийн мөшгөх цахим бүртгэлийн системийг нэвтрүүлсэн байна.	250.0	Гадаадын зээл, тусламж	50.0	50.0	50.0	50.0		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024-2028

2.5	2.5. Мал аж ахуй болон боловсруулах үйлдвэрлэлд зохистой дадлын стандартыг нэвтрүүлэх, олон улсын магадлан итгэмжлэл хийлгэхэд дэмжлэг үзүүлэх	Дотоодын баталгаажуулалтыг олон улсын хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагаар давхар баталгаажуулалт /магадлан итгэмжлэл/ хийлгэх	Магадлан итгэмжлэл хийлгэсэн хоршоо, үйлдвэрийн тоо	-	Хоршоо 20 үйлдвэр 5	1,000.0	Гадаадын зээл, тусламж	-	0	240.0	320.0	440.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Олон улсын төсөл, хөтөлбөр	2026-2028
2.6	2.6. Бэлтгэн нийлүүлэгчдийг чадавхжуулах	Түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийг стандартын дагуу түүхий эд бэлтгэхэд чадавхжуулах, мэргэжлүүлэх	Цахим контент бэлтгэж боломжит харилцааны холбооны сувгуудаар түгээсэн байх	-	Цахим контент бэлтгэж боломжит харилцааны холбооны сувгуудаар түгээсэн байна.	200.0	Гадаадын зээл, тусламж	-	100.0	100.0	-	-	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам,	2024-2026
2.7	2.7 Үндэсний боловсруулах үйлдвэрт тушаадаг хонь, тэмээний ноос, сарлагийн хөөвөр, бод малын арьс, ширний хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Үндэсний боловсруулах үйлдвэрт нийлүүлэх хонь, тэмээний ноос, сарлагийн хөөвөр, малын арьс ширэнд урамшуулал олгох замаар гарал үүсэл нь баталгаажсан, чанартай түүхий эдийг түүхий эдийн хэмжээг нэмэгдүүлэх	Мал аж ахуйн гаралтай, гарал үүсэл нь баталгаажсан, чанартай түүхий эдийг үндэсний үйлдвэрт нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх	Урамшууллын тогтолцоог сайжруулах шаардлагатай байгаа	Стандартын шаардлагын дагуу түүхий эд бэлтгэж нийлүүлэх тогтолцоо бүрдсэн байна.	177,000.0	Улсын төсөв	35,400.0	35,400.0	35,400.0	35,400.0	35,400.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2024-2028
2	Дүн					343,130.0	-	35,535.0	90,330.0	88,570.0	88,745.0	39,950.0		
Гурав Үйлдвэрлэлт, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх чиглэлээр:														
3.1.1	3.1. Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ашиглалтыг дээшлүүлэхэд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Ноос, ноолуур, арьс ширний бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн эргэлтийн хөрөнгийн зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх	Ноос, ноолуур арьс ширэн бүтээгдэхүүний экспортын өсөлт, хувиар	459.2 сая ам.долл	Жил бүр 10 хувиас багатай хэмжээгээр нэмэгдүүлнэ.	130,500.0	Улсын төсөв /ЭХ-н зээлийн хүүгийн дэмжлэг/	23,500.0	51,500.0	44,500.0	11,000.0	-	Сангийн яам, Монголбанк, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсын Хөгжлийн Банк Арилжааны банк	2024-2027
3.1.2		Шинэ, дэвшилтэт технологи бүхий ноолуурын эзрэх үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх	Ноолуурын эзрэх үйлдвэрлэлийн хүчин чадал	2,400 тонн	3000 тн	54,614.5	Улсын төсөв /ХО-н зээлийн хүүгийн дэмжлэг/	-	15,840.0	20,984.0	13,536.3	4,254.2	Сангийн яам, Монголбанк, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монгол Улсын Хөгжлийн Банк	2025-2028

[illegible]

3.4	3.4. Үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэлт, байгаль орчинд ээлтэй зохицой дэдлэн стандарт нэвтрүүлэлт зэрэг үйлдвэрлэлийн хөгжил дэвшлийн талаар мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах.	Сурталчлах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах тэргүүний сайн туршлагыг тодруулж бусдад түгээх	Зохион байгуулсан ажлын тоо	-	9-еос багагүй	450.0	Улсын төсөв	50.0	100.0	100.0	100.0	Ерөнхийлөгч ийн тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам МҮОНРТВ Олон улсын төсөл, хөтөлбөр	2024-2029
3.5.1	3.5.Баталгаажуулалтын тогтолцоог дэмжиж, олон улсын зах зээлд малын гаралтай бүтээгдэхүүний үнэ цэнийг өсгөхөд дэмжлэг үзүүлэх	Малын бэлчээр, эрүүл мэнд, арчилгаа маллагаа, таалаг байдал, үржүүлэг селект, түүхий эд бэлтгэл зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэхэд тавих зохистой дадлын үндэсний стандарт (Хариуцлагатай нүүдэлчин)-ын шаардлагыг хангасан хоршооны үйл явцыг баталгаажуулах, тохирлын гэрчилгээ олгоход дэмжлэг үзүүлэх	Тохирлын баталгаанд хамрагдсан хоршооны тоо	9	48	1,176.0	Улсын төсөв	126.0	189.0	245.0	280.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Баталгаажуул алтын байгууллагууд	2024-2028
3.5.2		Байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай тогтвортой үйлдвэрлэлийг нэвтрүүлсэн үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн үйл явцыг баталгаажуулах, тохирлын гэрчилгээ олгоход дэмжлэг үзүүлэх	Тохирлын баталгаанд хамрагдсан үйлдвэрийн тоо	5	29	262.5	Улсын төсөв	22.5	46.5	55.5	64.5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Баталгаажуул алтын байгууллагууд	2024-2028
3.5.3		Өндөр чанартай түүхий эд, бүтээгдэхүүнийг баталгаажуулах, гэрчлэх тэмдэгт (Монголын хаан ширхэгт) олгоход үзүүлэх	Гэрчлэх тэмдэгт авсан үйлдвэрийн тоо	4	18	217.0	Улсын төсөв	26.0	41.0	45.5	50.0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хоршоо, Баталгаажуул алтын байгууллага	2024-2028

3.5.4	Малын гаралтай түүхийг эдийн гарал үүслийг газар зүйн заалтаар тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Монгол Улсад бүртгэгдсэн газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүнийг гадаад улсын газар зүйн заалтад бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх.	Газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүнийг тодорхойлолтыг бэлтгэхэд холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, гадаад улстай газар зүйн заалтын тухай ариа хэлэлцээ хийх	Газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүнийг тодорхойлж, гадаад улсуудтай ариа хэлэлцээ хийсэн байх	"Монгол Улс, Европын Холбоо хооронд газар зүйн заалтын тухай" хэлэлцээр байгуулах хоёр талын яриа хэлэлцээг 2022 онд эхлүүлж, хоёр дахь үе шатны хурлыг 2023 онд зохион байгуулсан.	"Монгол Улс, Европын Холбоо хооронд газар зүйн заалтын тухай" хэлэлцээрийн хүрээнд малын гаралтай түүхийг бүтээгдэхүүнийг газар зүйн заалтын бүртгэлд хамруулах чиглэлээр ариа хэлэлцээг хийсэн байна.	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөр	250.0	0.00	35,221.9	130,752.5	108,305.2	51,212.4	13,183.9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Гадаад харилцааны яам, Оюуны өмчийн газар, мэргэжлийн холбоод	2024-2029
3	Дүн				338,675.9	0.00									
Дөрөв. Хүний нөөцийг бүрдүүлэх, дэмжих чиглэлээр															
4.1	4.1.Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт (YAMAT-08)-ыг боловсронгуй болгох	Нөөс, ноолуур, арьс ширний салбарын үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолтыг холбогдох яамтай хамтран шинэчлэн боловсруулж батлуулах	Салбарын ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолтыг боловсруулах, батлуулах	Салбарын зарим ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт орхигдсон байгаа.	Салбарын ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолтыг боловсруулах, батлуулах байна.	Улсын төсөв	200.0	-	-	-	-	-	-	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2025
4.2	4.2.Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах зорилгоор нийгмийн түншлэл буюу тарифын хэлэлцээр хийхэд дэмжлэг үзүүлэх	Салбарын ажилтнуудын цалингийн судалгаа хийх, ажлын бүтээмж, гүйцэтгэлтэй уялдсан, цалин хөлсний нэгдсэн систем боловсруулах, ажилтны мэргэжил, ур чадварыг хэмжих, үнэлэх, хөдөлмөрийн норм, норматив тогтоох, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх тарифын хэлэлцээр хийхэд дэмжлэг үзүүлэх	Тарифын хэлэлцээрийн тоо	0	1-зэс багагүй	Улсын төсөв	190.0	-	-	-	-	-	-	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Салбарын холбоод	2024-2025

4.3.1	4.3.Салбарын хүний нөөцийг бэлтгэх, сургах, чадавхжуулах	Гадаадын өндөр хөгжилтэй оронд инженер бэлтгэх, Ерөнхийлөгчийн илгээлт 2100" хөтөлбөрт хамруулах, дотоодын их дээд сургуулиудад боловсруулах салбарын боловсон хүчнийг бэлтгэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Гадаадад суралцагчийн тоо	0	50	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	2024-2028
4	Дүн					390.0	-	-	-	390.0	-	-	-	-	-	-	-		
	Нийт дүн					682,425.9	-	-	-	70,866.9	221,532.5	196,935.2	139,957.4	53,133.9					



63

2024/04/18 4:49:59

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар холбогдох материалыг судлан, санал зөвлөмжөө office@president.mn хаягаар ирүүлнэ үү.

1. Үзэл баримтлал
2. Танилцуулга
3. УИХ-ын тогтоолын төсөл
4. Үр нөлөөний үнэлгээ
5. Төндөн судалгааны тайлан
6. Зардлын тооцооны тайлан



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.05.15 № хэл/989
танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулсан "Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт 03 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000245007806

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэлд:

“14.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулсан “Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулсан “Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд зарчмын хувьд дэмжиж, дараах саналыг төсөл санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Тогтоолын төсөлд тусгагдсан зарим арга хэмжээ нь “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолд тусгагдсан арга хэмжээтэй давхардаж байна. Тухайлбал, тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийн 2.1-д тусгасан арга хэмжээ нь Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.6.1-д заасан “Биокомбинат” ТӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчлэх” арга хэмжээтэй, арга хэмжээний төлөвлөгөөний төслийн 2.2-т тусгасан арга хэмжээ нь Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.6.4-т заасан “Мал эмнэлгийн оношилгооны лабораторийг чадавхжуулах” арга хэмжээтэй тус тус давхардаж байгааг анхаарах.

2.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 1.6-д үйлдвэрлэл, технологийн парк (ҮТП)-ийг хөгжүүлэх татварын таатай орчныг бүрдүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх зорилгоор холбогдох татварын хуулиудад өөрчлөлт оруулах, мөн хэсгийн 3.а-д түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг тусгажээ. Энэ нь боловсруулах үйлдвэр, үйлдвэр технологийн паркийг татварын бодлогоор дэмжихээр Улсын Их Хурлаас баталсан дараах татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй давхардаж байна:

2.1.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын шийдвэрээр үйлдвэрлэл технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 хүртэлх жилээр сунгаж, энэ хугацаанд өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж, үндсэн үйл ажиллагаандаа ашигласан бол тухайн барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлнө;

2.2.Засгийн газрын шийдвэрээр хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирж байгаа техник, тоног

төхөөрөмж, түүний иж бүрдлийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 2 жил хүртэл хугацаагаар сунгах боломжтой;

2.3.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулийн хүрээнд малын гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлж байна;

2.4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөвөр, үйлдвэрийн аргаар төхөөрч бэлтгэн дотооддоо борлуулсан тураг болон шулж ангилсан мах, боловсруулаагүй дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүн, дотоодын түүхий эдээр боловсруулан дотооддоо борлуулсан хүнсний сүү, сүүн бүтээгдэхүүнийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж байна;

2.5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн хүрээнд жилийн 1.5 тэрбум төгрөгөөс доош борлуулалттай аж ахуйн нэгжүүдийн тус хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлж байна;

2.6.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21.3-т заасны дагуу орлогын босго хамаарахгүйгээр хувиараа бизнес эрхлэгч хувь хүн өөрийн хүсэлтээр хялбаршуулсан горимыг сонгож үйл ажиллагааны орлогын нийт дүнгийн 1 хувиар албан татвар төлөх боломжтой.

Түүнчлэн, малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийн экспортыг дэмжих зорилгоор бүтээгдэхүүнээ экспортод гаргахад гаалийн албан татвар ногдуулдаггүй бөгөөд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.21-д заасны дагуу экспортод гаргасан түүхий болон угаасан, самнасан ноолуур, арьс ширийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж, мөн хуулийн 12.1.1-д заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрээс экспортод гаргасан, гаалийн байгууллагад мэдүүлсэн бараанд нэмэгдсэн өртгийн албан татварын "0" хувь хэрэглэдэг болно.

Иймд тогтоолын төслийн 2 дахь заалтын 1.б, 3.а дахь дэд заалтын "татвар," гэснийг, тогтоолын төслийн хавсралтын 1.2.4-т заасан аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль тогтоомжид өөрчлөлт оруулж үйлдвэр технологийн паркийн татварын таатай орчин бий болгох агуулгатай заалтуудыг одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа татварын хууль тогтоомжтой уялдуулах.

3.Тогтоолын төслийн хавсралтын 2.4.1, 2.4.2-т туссан арга хэмжээнүүд нь хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй гадаад зээл, тусламжийн төслүүдийн гэрээ, хэлэлцээр болон төслийн хэрэгжилттэй холбоотой баримт бичигт тусгагдаагүй байх тул санхүүжилтийн эх үүсвэрийг "улсын төсөв болон бусад эх үүсвэр" болгон өөрчлөх.

4.Тогтоолын төслийн хавсралтын 3.1.1-д ноос, ноолуур, арьс ширний бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн эргэлтийн хөрөнгийн зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд ноос, ноолуур, арьс ширэн

бүтээгдэхүүний экспортын өсөлтийг жил бүр 10 хувиас багагүй хэмжээгээр нэмэгдүүлэхийг, төслийн 3.1.2-т шинэ дэвшилтэт технологи бүхий ноолуурын ээрэх үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд ноолуурын ээрэх үйлдвэрийн хүчин чадлыг 3,000 тонн болгохыг тус тус Сангийн яам болон бусад яам, байгууллагад даалгажээ.

Гэвч ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний экспортын өсөлт нь зөвхөн экспортыг дэмжсэн эргэлтийн хөрөнгийн зээл, зээлийн хүүгийн дэмжлэгээс хамааран өөрчлөгддөггүй бөгөөд ноолуурын ээрэх үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлснээр ээрэх үйлдвэрийн хүчин чадал тухайн хэмжээнд хүрэх эсэх нь тодорхой бус байх тул үйл ажиллагааны хүрэх түвшнийг уян хатан зохицуулах шаардлагатайг анхаарах.

5.Одоогийн байдлаар манай улсын ноос, ноолуур, арьс ширний угаах дамжлагын хүчин чадал нь нийт улсын боломжит нөөцөөс 10 гаруй дахин их байгаа боловч ээрэх үйлдвэрийн хүчин чадал нь боломжит хэмжээнээс 2 дахин бага байгаа тул малын гаралтай түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулах, үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг алдагдуулж байна.

Иймд “Цагаан алт” хөдөлгөөний хүрээнд хөрөнгө оруулалт нэн шаардлагатай, үйлдвэрийн хүчин чадал нь хүрэлцэхгүй байгаа ээрэх салбарт хөрөнгө оруулалтыг түлхүү олгох зарчмыг баримталж, эргэлтийн хөрөнгийн зээлийг үе шаттайгаар бууруулах нь зүйтэй байна.

Мөн тогтоолын төслийн хавсралтын 3.1.1 дэх заалтад 2024 оны эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн дэмжлэгт зориулан 23.5 тэрбум төгрөг тусгасан байгаа нь Монгол Улсын 2024 оны батлагдсан төсөвт тусгагдаагүй тул 2025 оны төсвийн жилээс эхлэн хэрэгжүүлэхээр тусгах.

6.Малын гаралтай түүхий эдийн үнийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын гол үндэс нь малчид, малын чанартай түүхий эд бэлтгэх зөв тогтолцоог бүрдүүлэх асуудал байх тул тогтоолын төсөлд чанартай түүхий эд бэлтгэх, малын үйлдвэр угсааг сайжруулах, мал, түүхий эдийг чанаржуулах чиглэлийн ажлуудыг тусгах.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**“МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙГ БОЛОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Удиртгал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу урьдчилсан байдлаар тооцлоо.

Тогтоолын төсөл батлагдан хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал үүсэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой. Тогтоолын төслийн зохицуулалтууд нь хуулийн этгээд болон иргэнд шинээр зардал үүсэхгүй болно.

Зардал тооцсон субъект:

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн Хоёр. “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих “Цагаан алт” хөдөлгөөнийг өрнүүлэх хүрээнд:

2.1.а. Хөнгөн үйлдвэрлэлд хамаарах салбар, оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих, хөгжүүлэх, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2.1.е. Дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг ахиулахтай холбоотой зайлшгүй шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг батлан хэрэгжүүлэх;

2.2.а. Малыг эрүүлжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт технологи бүхий дотоодын вакцин үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, мал вакцинжуулах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, тогтолцоог сайжруулах;

2.2.б. Улсын болон аймгийн мал эмнэлэг, ариун цэврийн лабораториудын үйл ажиллагааг уялдуулан, стандартын шаардлага хангасан өндөр хүчин чадалтай бүсийн мал эмнэлгийн лабораториудыг байгуулж, орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах;

2.2.в. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд суурилсан хөдөө аж ахуйн тэргүүлэх бүсүүдэд дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын тайван бүсийн үзүүлэлтүүдийг тогтоож, тогтвортой хадгалах;

2.2.г. Малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр дамжуулан арилжаалах, түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалтыг бий болгох замаар нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх;

2.2.д. Түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцооны цахим санг хөгжүүлж, гарал үүсэл, чанар нь баталгаажсан түүхий эдийг үндэсний үйлдвэрт нийлүүлэх, экспортод гаргахыг дэмжих;

2.2.е. Түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийг стандартын дагуу түүхий эд бэлтгэхэд чадавхжуулах, мэргэшүүлэх;

2.3.а. Түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд татвар, зээлийн хүүгийн бодлогоор дэмжлэг үзүүлэх;

2.3.б. Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг бүсийн онцлогт тулгуурласан үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахад чиглүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгийг улсын төсөв тусган хэрэгжүүлэх;

2.3.в. Эцсийн бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэхэд чиглэсэн бодлогоор дэмжиж, үндэсний үйлдвэрүүдийг олон улсын томоохон үзэсгэлэнгүүдэд тогтмол оролцоход дэмжлэг үзүүлэх,

2.3.г. Байгаль орчин, мал амьтанд ээлтэй, тохирлын баталгаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үйл явцыг баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх;

2.3.д. Нэмүү өртөг шингэсэн, байгаль орчинд ээлтэй шинэ, дэвшилтэд технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, байгаль орчинд эерэг нөлөөтэй, зохистой дадал, стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийг ногоон санхүүжилтэд хамруулах, арга туршлагыг нийтэд таниулах арга хэмжээг зохион байгуулах;

2.3.е. Үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт, шинэ дэвшилтэд технологи нэвтрүүлэлт, байгаль орчинд ээлтэй тогтолцооны болон зохистой дадлын стандартын хэрэгжүүлэлт, баталгаажуулалт зэрэг үйлдвэрлэлийн хөгжил дэвшлийн талаар мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах;

2.4.а. Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт (YAMAT-08) болон сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг салбарын холбоодтой хамтран зохион байгуулах;

2.4.д. Үндэсний ажил мэргэжлийн стандарт ба цалин хөлсний бодлогыг боловсруулах, ажилтнуудын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, хүн төвтэй зохистой хөдөлмөрийн харилцааг төлөвшүүлэх Тарифын хэлэлцээр боловсруулах, хэрэгжүүлэх талаарх зохицуулалтыг тусгасан байна.

Энэ зохицуулалтын дагуу Улсын төсөвт тусгагдах шаардлага гарч ирэхтэй холбогдуулан төсөвт нөлөөлөл үзүүлэх зардлыг тооцов.

Тогтоолын төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг тооцохдоо дараах нийтлэг зарчмыг баримталсан. Үүнд:

- ✓ өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, тогтоомжид тусгаагүй байсан тогтоолын төсөлд шинээр орсон зардлыг тооцох;
- ✓ үнэн бодит тоо мэдээлэлд тулгуурлах;
- ✓ тогтоолын төслийг 2024 оноос хэрэгжинэ гэж үзэн зардлыг тооцох;

Хуулийн этгээдийн зардал.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд санхүүгийн нөлөөлөл үүсэхгүй.

Иргэний үүсэх зардал.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөл батлагдсанаар иргэнд санхүүгийн нөлөөлөл үүсэхгүй.

Улсын төсөвт үүсэх зардлын тооцоо

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2.1-д заасан Салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр шаардлагатай байгаа 230.0 сая төгрөгийн, 2.2-т заасан Түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог дэмжих чиглэлээр шаардлагатай байгаа 343.1 тэрбум төгрөгийн, 2.3-т заасан Үйлдвэрлэлт, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх чиглэлээр шаардлагатай байгаа 338.7 тэрбум төгрөгийн, 2.4-т заасан Салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, дэмжих чиглэлээр шаардлагатай байгаа 390.0 сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг тус тус шийдвэрлэх заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах шууд зардал болон бусад зардлыг Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар төрд тодорхой хэмжээний зардал нэмэгдэнэ гэж үзэн зөвхөн төрд үүсэх зардлын тооцлоо. Үүнд:

1. Салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд шаардлагатай зардлын тооцоо.

№	Гарах зардлын тооцоо	Дүн /сая.төгрөг
1	"Хөнгөн үйлдвэрлэлийн тухай" хуулийн төслийг шинээр боловсруулахад шаардлагатай судалгаа, хэлэлцүүлгийн зардал	50.0
2	Дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг ахиулахтай холбоотой зайлшгүй шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулан батлуулах	180.0
	Нийт	230.0

2. Түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог дэмжихэд шаардлагатай зардлын тооцоо.

№	Гарах зардлын тооцоо	Дүн /сая.төгрөг
1	Биокомбинат ТӨХХ-ийн өргөтгөл шинэчлэлийг хийх	129,300.0
2	Улсын болон аймгийн мал эмнэлэг, ариун цэврийн лабораториудын үйл ажиллагааг уялдуулан, стандартын шаардлага хангасан өндөр хүчин чадалтай бүсийн мал эмнэлгийн лабораториудыг байгуулж, орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах	30,000.0
3	Хөдөө аж ахуйн биржийн худалдааг зах зээлийн	5,000.0

	зохион байгуулалтад оруулах, түүхий эдийн чанар, стандартыг сайжруулах, хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо нэвтрүүлэх	
4	Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэл, чанар, гарал үүслийг мөшгөх цахим бүртгэлийн системийг бий болгож, хөгжүүлэх	380.0
5	Түүхий эдийн бэлтгэл, чанар, гарал үүслийн мөшгөх цахим бүртгэлийн системийг нэвтрүүлэх	250.0
6	Дотоодын баталгаажуулалтыг олон улсын хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагаар давхар баталгаажуулалт /магадлан итгэмжлэл/ хийлгэх	1,000.0
7	Түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийг стандартын дагуу түүхий эд бэлтгэхэд чадавхжуулах , мэргэшүүлэх	200.0
8	Үндэсний боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, хонь, тэмээний ноос, сарлагийн хөөвөр, малын арьс ширэнд урамшуулал олгох замаар гарал үүсэл нь баталгаажсан, чанартай түүхий эдийг түүхий эдийн хэмжээг нэмэгдүүлэх	177,000.0
	Нийт	343,130.0

3. Үйлдвэрлэлт, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэхэд шаардлагатай зардлын тооцоо.

№	Гарах зардлын тооцоо	Дүн /сая.төгрөг
1	Ноос, ноолуур, арьс ширний бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн эргэлтийн хөрөнгийн зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх	130,500.0
2	Шинэ, дэвшилтэт технологи бүхий ноолуурын ээрэх үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх	54,614.5
3	Шинэ, дэвшилтэт технологи бүхий ноос боловсруулах/ ээрэх, сүлжих, нэхэх, хялгас ялгах/ үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, технологийг сайжруулах хөрөнгө оруулалтын зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх	85,815.5
4	Үйлдвэрийн үйл ажиллагаандаа байгальд ээлтэй технологи, хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах технологи нэвтрүүлсэн арьс, ширний гүн боловсруулах болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын зээл, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх	33,335.0
5	Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн парк /ҮТП/-ын дэд бүтцийн бүтээн байгуулалт	31,305.4
6	Олон улсын үзэсгэлэнд оролцоход дэмжлэг үзүүлэх	750.0
7	Сурталчлах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах, тэргүүний сайн туршлагыг тодруулж бусдад түгээх	450.0

8	Малын бэлчээр, эрүүл мэнд, арчилгаа маллагаа, тавлаг байдал, үржүүлэг селекц, түүхий эд бэлтгэл зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэхэд тавих зохистой дадлын үндэсний стандарт (Хариуцлагатай нүүдэлчин)-ын шаардлагыг хангасан хоршооны үйл явцыг баталгаажуулах, тохирлын гэрчилгээ олгоход дэмжлэг үзүүлэх	1,176.0
9	Байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай тогтвортой үйлдвэрлэлийг нэвтрүүлсэн үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн үйл явцыг баталгаажуулах, тохирлын гэрчилгээ олгоход дэмжлэг үзүүлэх	262.5
10	Өндөр чанартай түүхий эд, бүтээгдэхүүнийг баталгаажуулах, гэрчлэх тэмдэгт (Монголын хаан ширхэгт) олгоход үзүүлэх	217.0
11	Малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг газар зүйн заалтаар тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Монгол Улсад бүртгэгдсэн газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүнийг гадаад улсын газар зүйн заалтад бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх.	250.0
Нийт		338,675.9

4. Хүний нөөцийг бүрдүүлэх, дэмжихэд шаардлагатай зардлын тооцоо.

№	Гарах зардлын тооцоо	Дүн /сая.төгрөг
1	Ноос, ноолуур, арьс ширний салбарын үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолтыг холбогдох яамтай хамтран шинэчлэн боловсруулж батлуулах	200.0
2	Салбарын ажилтнуудын цалингийн судалгаа хийх, ажлын бүтээмж, гүйцэтгэлтэй уялдсан, цалин хөлсний нэгдсэн систем боловсруулах, ажилтны мэргэжил, ур чадварыг хэмжих, үнэлэх, хөдөлмөрийн норм, норматив тогтоох, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх тарифын хэлэлцээр хийхэд дэмжлэг үзүүлэх	190.0
Нийт		390.0

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах нийт зардал 682.4 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай байна. Гэхдээ зардлын тооцоонд өөрчлөлт гарах үндэслэлтэй бөгөөд улсын төсөв, гадаадын зээл тусламжийн эх үүсвэрээс хамтран хэрэгжүүлэх боломжтой ажлууд байгаа тул нийт зардлын тооцоо өөрчлөгдөхөөр тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

---oOo---

**МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙН БОЛОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ТУХАЙ ТАЙЛАН**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогод боловсруулах үйлдвэрлэл, тэр дундаас мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг байгальд ээлтэй байдлаар хөгжүүлэх, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилт тусгагдсан.

Аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагаас 6,314 (80.5 хувь) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс хөнгөн үйлдвэрийн салбар нь ноос ноолуур, арьс шир, мод, модон тавилга, оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэл, хэвлэл, сав баглаа боодол, дахин боловсруулах, гоо сайхан, ахуйн химийн нийт 3,200 гаруй аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж, 44,000 орчим хүн ажиллаж байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2022 онд 43.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 8.6 (24.4 хувиар) их наяд төгрөгөөр, 2018 оноос 16.3 (59.7%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Үүнд боловсруулах үйлдвэрлэлийн салбар 2.8 (25.6%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хөнгөн үйлдвэрлэлийн салбар 2023 онд нийтдээ 484.8 сая ам долларын экспорт, 1,077.5 сая ам долларын импорт хийсэн байна.

Хөнгөн үйлдвэрийн салбарын экспорт, импорт /сая ам.долл/

Барааны нэр	Экспорт						Импорт					
	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн	409.8	434.6	279.5	370.7	489.7	451.2	90.2	85.0	85.8	103.7	133.8	150.7
Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	17.0	14.1	7.4	6.4	5.2	4.7	8.3	7.1	5.0	6.4	9.3	9.5
Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	2.3	2.5	1.8	2.2	2.1	3.2	19.9	19.8	17.8	24.6	35.1	36.2
Мод, модон эдлэл	0.3	0.6	0.3	0.1	0.3	0.3	34.0	43.5	43.4	67.3	81.7	79.5
Цаас болон картон, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүн	0.04	0.05	0.04	0.03	0.3	0.1	61.6	56.4	58.1	64.3	98.1	78.4
Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс	1.6	1.3	1.6	1.2	10.2	21.8	226.8	260.3	226.8	260.2	345.2	359.6
Нийт	431.04	453.15	290.64	380.63	507.8	484.8	440.8	472.1	436.9	526.5	703.2	1,077.5

Хөнгөн үйлдвэрлэлийн салбар 2023 онд нийтдээ 484.8 сая ам долларын экспорт хийсний 93 хувь буюу 451.2 сая ам долларыг нэхмэлийн буюу ноос, ноолуурын салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

Мөн онд нийтдээ 1,077.5 сая ам долларын импорт хийсэн ба импортын дийлэнх хувь буюу 52 хувийг мод, цаас, хуванцар, түүгээр хийсэн эдлэл буюу мод, хэвлэл, сав баглаа боодлын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн эзэлж байна



Хөнгөн үйлдвэрийн экспортын гол бүтээгдэхүүн болох ноос, ноолууран бүтээгдэхүүний экспорт 2020 онд олон улсад тархсан Ковид-19 цар тахалтай холбоотойгоор уналттай байсан бол Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлсний үр дүнд богино хугацаанд сэргээд байна.

Ноолуурын экспортыг биет хэмжээгээр авч үзвэл угаасан ноолуурын экспорт 2023 онд 5,449.1 тн (263,9 сая. ам.долл) болж өмнөх оноос 15 хувиар буурсан бол самнасан ноолуурын экспорт 1,001.1 тн (95.9 сая. ам.долл) болж өмнөх оноос тоо хэмжээгээр 16.8 хувиар, үнийн дүнгээр 3.1 хувиар өссөн байна.



Манай улс жилд дунджаар 49.8 мян.тонн ноос, ноолууран түүхий эд бэлтгэх нөөцтэй байна. Үүнээс хонины ноос 37.0 мян.тонн, ямааны ноолуур 10.0 мян.тонн, тэмээний ноос 2.0 мян.тонн, сарлагийн хөөвөр 400 тонн байна.

Түүхий эдийн ашиглалтыг авч үзвэл сарлагийн хөөврийн бэлтгэл 20 гаруй хувьтай, бусад түүхий эдийн бэлтгэл 100% байна.

Ноос, ноолуурын боловсруулалтын түвшин харилцан адилгүй байна. Үүнд:

- Ямааны ноолуурын 70 гаруй хувь нь угаасан, 10 орчим хувь нь самнасан, 20 орчим хувь нь бэлэн бүтээгдэхүүн,
- Тэмээний ноосны 70 хувь нь угаасан, 20 хувь нь самнасан, 10 хувь нь бэлэн бүтээгдэхүүн,
- Хонины ноосны 75 нь хувь угаасан, 25 хувь нь бэлэн бүтээгдэхүүн;
- Сарлагийн хөөвөр 100% бэлэн бүтээгдэхүүн болж байна.

Ноос, ноолууран түүхий эд дундаас 100% эцсийн бүтээгдэхүүн болдог сарлагийн хөөврийн нөөцийн ашиглалт 20 гаруйхан хувьтай байсан тул сарлагийн хөөврийн бэлтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 87 тогтоол баталсан ба 2024 оноос эхлэн малчдын бэлтгэсэн сарлагийн хөөврийн нэг кг тутамд 10,000 төгрөгийн урамшуулал олгоно.

Өнөөгийн байдлаар ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн дараах үйлдвэрлэлийн хүчин чадал суурилагдсан байна. Үүнд:

- Угаах 47 үйлдвэрт 101.0 мян.тонн ноос, ноолуур угаах;
- Хялгас ялгах 50 үйлдвэрт 11.9 мян.тонн хялгасыг нь ялгасан буюу самнасан ноолуур гаргах;
- Ээрмэлийн 18 үйлдвэрт 3 мян.тонн ээрмэл гаргах;
- Сүлжих, нэхэх эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч цогцолбор 14, жижиг дундын 100 гаруй үйлдвэрт 5.3 сая ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн, 2.5 сая метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Хивсний 2 үйлдвэрт 1.6 сая метр хивс үйлдвэрлэх;
- Нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх 3 үйлдвэрт 3.5 сая метр
- Ноосон бордооны 1 үйлдвэрт 3 мян.тонн ноосон бордоо үйлдвэрлэх;
- Ноосон дулаалгын 4 үйлдвэрт 0.8 мян.метр дулаалгын материал үйлдвэрлэх;
- Шивмэл эсгийний 3 үйлдвэрт 1.2 сая метр шивмэл эсгий үйлдвэрлэх;
- Эсгийн 160 гаруй цехэд 4.6 сая метр эсгий үйлдвэрлэх хүчин чадал тус тус суурилагдсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоол, Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2021 оны 02 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоол батлагдаж, 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн самнасан ноолуур экспортлох техникийн зохицуулалт хийсэнтэй холбогдуулан 2022, 2023 онуудад нийт 15 үйлдвэрт 4163 тонн хүчин чадал бүхий ноолуурын хялгас ялгах тоног төхөөрөмж шинээр суурилагдсан байна. Үүнээс 2022 онд 3 үйлдвэрт 297 тонн, 2023 онд 12 үйлдвэрт 3,866 тонн хялгас ялгах хүчин чадал суурилагджээ.

Өнөөгийн байдлаар Улаанбаатар хотод байрлах 45, орон нутагт байрлах 5 нийт 50 хялгас ялгах үйлдвэрт 11.9 мян.тонн самнасан ноолуур гаргах өөрөөр хэлбэл 23.8 мян.тонн түүхий ноолуурыг угаагаад самнах хүчин чадал суурилагдаж, манай улс ноолуураа дотооддоо бүрэн самнах боломж бүрдсэн.

Цаашид ноолуурын боловсруулалтын түвшний шат ахиулж, ээрэх үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг дэмжих дотоодын сүлжмэлийн үйлдвэрүүдийг ээрмэлээр хангах арга хэмжээг авах шаардлагатай байна.

Манай улс жилд дунджаар 18 сая ширхэг арьс, ширэн түүхий эдийн нөөц байгаагаас 9.1 сая ширхэг хонины арьс, 7.4 сая ширхэг ямааны арьс, 09 сая ширхэг үхрийн шир, 0.6 сая ширхэг адууны шир бэлтгэх нөөц байна.

Арьс шир боловсруулах салбарт нийт 14.9 сая ширхэг арьс ширийг хагас боловсруулах, 700 мян.ширхэг бодын шир, 1.7 сая ширхэг богийн арьс ширийг гүн боловсруулах хүчин чадал суурилагдсан байна.

Цаашид арьс шир боловсруулах салбарт гүн боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй, шинэ дэвшилтэт технологийн нэвтрүүлэх шаардлагатай байна.

Бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн хувьд жилдээ 20 мян.ширхэг савхин хувцас, 20 мянган ширхэг нэхий хувцас, 5 сая ширхэг нэхий бээлий болон 500 мянган ширхэг хос гутлыг тус тус үйлдвэрлэх хүчин чадал суурилагдсан байна.

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогод тусгагдсаны дагуу түүхий эдийн нөөцөд түшиглэн арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр үйлдвэрлэл, технологийн паркийг бүсчлэн хөгжүүлэхээр ажиллаж байна.

Эхний ээлжид баруун бүсэд “Шинэ Ховд” УТП, төвийн бүсэд “Дархан арьс ширний цогцолбор”, Улаанбаатарт “Эмээлт” эко аж үйлдвэрийн парк, Говийн бүсэд “Говьсүмбэр мал аж ахуй шинжлэх ухааны үйлдвэрлэл, технологийн парк”, Зүүн бүсэд “Дорнод хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк”-уудыг байгуулахаар тус тус төлөвлөн ажиллаж байна.

Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх хүрээнд баруун бүсэд “Шинэ Ховд” үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахаар дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна.

Тус үйлдвэрлэл, технологийн паркт жилд 1 сая ширхэг арьс шир, 3 мян.тонн ноос, 300 тонн ноолуур боловсруулах хүчин чадал бүхий 25 үйлдвэр байгуулахаар төлөвлөж, паркийн авто зам, цахилгаан, дулаан, холбоо, инженерийн шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн 5 багц ажлын бүтээн байгуулалтыг 2023 онд эхлүүлж, 2024 онд дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд гаднын томоохон худалдан авагчид түүхий эд бүтээгдэхүүнийг худалдан авахдаа чанараас гадна байгаль орчинд ээлтэй байх, малын тавлаг байдлыг хангасан байх гэдэг шаардлагыг ихээхэн анхаардаг болсон.

Монгол ноолуурын чанарт тулгуурлан “Монголын хаан ширхэгт” бүтээгдэхүүний стандартыг баталсан ба уг стандартын шаардлага хангасан хамгийн нарийн микронтой, сайн чанарын ноолуурыг баталгаажуулж, гэрчлэх тэмдэгт олгох ажлыг салбарын мэргэжлийн холбоотой хамтран хэрэгжүүлж байна

Мөн монгол орны бэлчээрийн мал аж ахуй, ялангуяа монгол малчдын дунд байгаа өвөрмөц арга ажиллагааг мал, амьтны эрх чөлөөний нийтлэг зарчим, орчин цагийн органик үйлдвэрлэлд тавигдах шаардлагатай уялдуулах, текстилийн

үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг нэвтрүүлэх зорилгоор “Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг хэрэгжүүлэхэд тавих шаардлагууд” болон “Текстилийн тогтвортой үйлдвэрлэл” зохистой дадлын стандартуудыг боловсруулан үндэсний стандартаар баталсан.

Энэхүү стандартуудын шаардлагыг хангасан малчид, хоршоод, үйлдвэрлэгчдийг баталгаажуулах ажлыг баталгаажуулалтын эрх бүхий байгууллагуудаар баталгаажуулах ажлыг дэмжин хэрэгжүүлж байна.

Цаашид дээрх стандартуудын шаардлага хангасан, тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг тууштай дэмжих замаар мал аж ахуй болон боловсруулах үйлдвэрлэлийг байгальд ээлтэй байдлаар хөгжүүлэх боломжтой юм.

Монгол Улсын Засгийн газраас ноолуур боловсруулах үндэсний үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, улмаар түүхий эдийг үнийн уналтаас хамгаалах, үнэ тогтворжуулах зорилгоор түүхий эд бэлтгэлд зориулан хөнгөлөлттэй зээлийг олгож байна

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд 2021 онд ноос, ноолуурын 42 үйлдвэрт 98.1 тэрбум, арьс ширний 9 үйлдвэрт 13.2 тэрбум, 2022 онд 33 үйлдвэрт 134.9 тэрбум, арьс ширний 8 үйлдвэрт 7.1 тэрбум, Засгийн газрын 2023 оны 64 дүгээр тогтоолын дагуу ноолуур бэлтгэлийн зориулалтаар 34 аж ахуйн нэгжид 169.1 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэр, хөнгөлөлттэй зээлийн үр дүнд ноос, ноолуурын салбарт 528, арьс ширний салбарт 101 ажлын байр шинээр нэмэгдэж, үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж, тухайлбал хялгас ялгах үндэсний үйлдвэрүүдийн хүчин чадал 1800 тонн, ээрэх үйлдвэрийн хүчин чадал 160 тонноор нэмэгдсэн байна. Мөн түүхий ноолуурын үнэ 2023 онд 2022 онтой харьцуулахад 15-20 хувийн өсөлттэй байсан. Самнасан ноолуурын экспорт тогтвортой өсөлттэй байна.

Өнөөдөр дэлхий даяар бидний ашиглаж байгаа байгалийн эх үүсвэрийн хэрэглээ, гаргаж байгаа хог хаягдлын хэмжээ нь дэлхийн нөөц, чадавхаас үлэмж хэтрээд байна. Үүнийг экологийн ул мөр гэдэг ойлголтоор тайлбарлавал эх дэлхий бидний хэрэглээг гүйцэж үйлдвэрлэж амжихгүй байгаа буюу хүн төрөлхтний хэрэглээг нэг биш 1,5 дэлхий хангахаар нөхцөл үүсээд байна (Global Footprint Network report, 2014 он). Энэхүү хэтийдсэн хэрэглээнээс болоод даян дэлхийн эко систем доройтож, биологийн олон төрөл зүйл алдагдаж улмаар эх дэлхийн нэг жилийн туршид үйлдвэрлэх нөөц баялгийн хэмжээ болон хог хаягдлыг шингээх чадавх зогсолтгүй буурч байна. Хүн төрөлхтний экологийн сөрөг ул мөр жил бүр өсөж байна. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэх үүднээс 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганы үеэр “Тогтвортой Хөгжлийн Зорилтууд (ТХЗ)”-ыг баталсан. ТХЗ-д нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн үндсэн гурван хүчин зүйлд тулгуурлан, харилцан шүтэлцээтэй үйлдэл, үйл ажиллагаагаар хангах ба дэлхийн улс орнууд, улс орон бүрийн төр, хувийн хэвшил, иргэн бүр хамтдаа хөгжих, хөгжлөөс хэн ч үлдэх, хоцрох ёсгүйг онцолжээ. Өөрөөр хэлбэл ТХЗ-ын үндсэн үзэл санаа нь өнөө үеийн хэрэгцээг хангахдаа ирээдүй үеийн хэрэгцээгээ хангах боломжийг хязгаарлахгүй байх буюу тогтвортой хөгжих явдал юм.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1 Асуудлыг тодорхойлж, асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоосон байдал

Сүүлийн жилүүдэд өндөр хөгжилтэй орны хэрэглэгчид байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэл болон гарал үүсэл тодорхой бүтээгдэхүүний худалдан авалт руу хандаж байгаа энэ үед ноос, ноолуур, сарлаг, тэмээний ноос, арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих нь малчдын орлогыг өсгөх боломж болохын зэрэгцээ Монгол Улсын байгаль орчин, өв соёлыг хамгаалан хадгалахад өндөр ач холбогдолтой юм.

Улмаар чанарыг бэхжүүлэх, олон улсын стандартыг дагаж мөрдсөнөөр экспортыг өсгөх, Монголын компаниудын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, шинэ хөрөнгө оруулалтыг татахад чухал ач холбогдолтой байна.

Монгол Улсын Их Хурлаас “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталж, Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болох алсын харааг дэвшүүлжээ.

Дэлхийн текстилийн ширхэгтийн нийт үйлдвэрлэлийн хэмжээ 2021 онд 109 сая тонн байгаагаас амьтны гаралтай ширхэгт 1.7 хувь, үүнээс 1.5 хувийг ноосон ширхэгт, 0.02 хувийг ямааны ноолууран ширхэгт эзэлж байна.

Энэхүү ховор онцлог ширхэгт болох ноолуурын нөөцийн 48 орчим хувийг Монгол улс, 50 орчим хувийг БНХАУ, үлдсэн хувийг нь Иран, Афганистан, Казахстан зэрэг улсууд бэлтгэж дэлхийн зах зээлд нийлүүлдэг.

Монгол Улс нь дэлхийн ноолуурын 50 орчим хувийг үйлдвэрлэдэг бөгөөд нийт ноолуурынхаа 70-80 хувийг зөвхөн угаагаад БНХАУ-д экспортолдог байсан бол 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ноолуураа угаасан бус бүрэн самнаж экспортлох шийдвэрийг Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас гаргаж, техникийн зохицуулалт баталсан.

Цаашид ноосны хялгас ялгах, ноос, ноолуурын зэрэх, сүлжих, нэхэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өндөр бүтээмжтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолоор хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд 2011 оноос хойш нийт 268.1 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Ноосонд урамшуулал олгосноор ноосны салбарт шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл тухайлбал, ноосон дулаалга, ноосон бордоо, ноосны хялгасыг нь ялгаж сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэн хэдий ч тус салбарын эдийн засагт үзүүлэх хувь нэмэр болон ноосны боловсруулалтын түвшин төдийлөн сайн өсөөгүй байна.

Мөн “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолоор арьс, шир бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд 2013 оноос хойш нийт 77.0 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Өнөөгийн байдлаар арьс ширний нөөцийн 30 хүрэхгүй хувийг үндэсний боловсруулах үйлдвэрт нийлүүлэгдэж байна. Тухайлбал жилд 3.4 сая ширхэг арьс ширэнд хагас боловсруулалт, 1.2 сая ширхэг арьс ширэн гүн боловсруулалт, нийт 4.6 сая ширхэг нь боловсруулагдаж, 13.4 сая ширхэг арьс ширийг боловсруулж чадахгүй байна.

Үндэсний үйлдвэрүүдийн боловсруулсан арьс, ширээр, гутал, цүнх, хувцас, савхин эдлэл үйлдвэрлэж байгаа боловч гадаад зах зээлийн хэрэгцээ шаардлага, түүхий эдийн гэмтлээс шалтгаалан үндэсний үйлдвэрүүдийн худалдан авах хэмжээ бага байгаагаас түүхий эдийн үнэ сүүлийн 10 жил нэмэгдээгүй нь малчдын орлогод сөргөөр нөлөөлж байна.

Өнөөгийн арьс ширний бэлтгэл, урамшууллын тогтолцоог өөрчлөн мах төхөөрөх үйлдвэрүүдээр дамжуулан арьс ширээ бэлтгэх замаар нядалгааны үеийн арьс, ширний гэмтлийг бууруулах, махны үйлдвэрт нийлүүлсэн малын эрүүл мэнд, гарал үүслийг мөшгөн малын амьд байх үеийн гэмтлийг хянах, улмаар түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах боломж бүрдэнэ.

Иймд арьс шир бэлтгэсэн малчдад олгож буй урамшууллыг малчдад шууд өгөх бус, мал төхөөрөх үйлдвэрүүдтэй холбох, уг үйлдвэрүүд нь эрүүл, чанартай мал нийлүүлсэн малчдаа урамшуулдаг тогтолцоо руу урамшууллын бодлогыг чиглүүлэх нь зүйтэй байна.

Малын бие махбодын биологийн болон гадна орчны физик, механик, химийн нөлөөллөөс арьсанд үүссэн өөрчлөлт гэмтэл нь арьс, ширний таваарлаг чанар, үнэлгээг бууруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд бэрхшээл учруулдаг.

Бэлтгэгдэж буй арьс ширний дийлэнх их хэмжээний гэмтэлтэй байгаа нь нэг талаас эцсийн бүтээгдэхүүний үнэ цэнийг бууруулаад зогсохгүй нөгөө талаас боловсруулалтын зардлыг нэмэгдүүлдэг.

Малын амьд байхад үүссэн гэмтэл малын үс ноосонд далдлагдаж байдаг учир боловсруулагдаагүй арьсны чанар тодорхойлох үед сайн ажиглагдахгүй, харин арьс, ширний үйлдвэрт боловсруулах явцад илрэн гарч бүтээгдэхүүний чанар, гарцыг бууруулдаг.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 2021 оны судалгаанаас үзвэл бог малын арьсанд хачиг, хамууны гэмтэл үүнээс гадна шивээний гэмтэл, харин адууны ширэнд тамганы сорви их байсан байна.

Иймд бог малыг бүрэн эрүүлжүүлэх, мал сүргийнхээ арьсанд механик гэмтэл үүсгэхгүй байх талаар малчдад сургалт хийх шаардлагатай байна.

Түүнчлэн 2025 оноос хэрэгжиж эхлэх махны техникийн зохицуулалттай уялдуулан мал төхөөрөх үйлдвэрүүд, арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн хамтын

ажиллагааг сайжруулах замаар арьс ширний нядалгааны үеийн гэмтлийг бууруулах боломжтой юм.

Нөгөөтээгүүр арьс ширний гүн боловсруулалтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй, орчин үеийн дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх шаардлагатай байна.

Хөнгөн үйлдвэрийн салбарын эрхзүйн орчин дутмаг, түүхий эдийн болон бүтээгдэхүүний чанар, бэлтгэл болон ханган нийлүүлэлтийн тогтолцоо сул, эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн нөхцөл муу, мэргэжлийн хүний нөөцийн дутагдал, урамшууллын бодлого оновчгүй зэрэг тулгамдсан асуудал байна.

Сүүлийн жилүүдэд шинээр батлагдсан зарим хууль тогтоомжийг дагаад хөнгөн үйлдвэрийн салбарын мэргэшсэн, зөвлөх, тэргүүлэх инженерүүдийг сурган баталгаажуулж, гэрчилгээжүүлэх ажлууд орхигдсон, түүхий эдийн урамшууллын бодлогыг өөрчлөн сайжруулах боломжгүй байгаа зэрэг нь тус салбарын тулгамдсан асуудлыг улам нэмэгдүүлсээр байна.

Мөн ижил нэрийн барааны импорт болон худалдааны хяналтын тогтолцоо байхгүйгээс дотоод зах зээлээ хамгаалж чадахгүй байгаа төдийгүй хэрэглэгчдийг төөрөгдүүлж, иргэд эдийн засгийн хувьд хохирч байна. Энэ байдал нь үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд ч саад болж байна.

Харин хөнгөн үйлдвэрийн бусад салбарын хувьд өөр өөрийн онцлог давуу чанартай, технологийн хувьд эрс ялгаатай үйлдвэрлэл бөгөөд тэдгээрийн зарим нь зах зээлийн зарчмаараа хөгжих боломжтой.

Иймд хөнгөн үйлдвэрийн салбар, тэр дундаас мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогод нийцүүлэн хөгжүүлэх, нэмүү өртөг бүтээх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төрөөс дэмжих шаардлагатай байгаа ба дараах чиглэлээр оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Үүнд:

1. Хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүй, санхүү, хөрөнгө оруулалт, татварын таатай, тогтвортой орчныг бүрдүүлэх чиглэлээр;
2. Байгаль орчин, мал амьтанд ээлтэй, өндөр чанартай түүхий эд бэлтгэл, түүний гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцоог дэмжих чиглэлээр;
3. Үйлдвэрлэлийн хүчин чадал, түүний ашиглалтыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх чиглэлээр;
4. Хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр.

Мал аж ахуйн үйлдвэрлэлээс гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хамгийн оновчтой хувилбарыг тогтоохдоо Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ыг баримтлан хууль, тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлов.

1.2 Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага болон бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг

Д/д	Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
	Хэрэглэгчид	Олон улсын болон Монгол Улсын стандартын шаардлага хангасан брэнд, нэр хүндтэй бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэн, маркетингийг хөгжүүлснээр дотоод, гадаадын хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлага хангагдаж, сэтгэл ханамж нэмэгдэнэ. Хуурамч бүтээгдэхүүнээс хамгаалагдах хэрэглэгчийн эрх ашиг хангагдана. Мал ах ахуй болон боловсруулах үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй байдлаар хөгжүүлснээр байгаль орчинд ялгарч буй хүлэмжийн хий багасаж, цаг агаарын дулаарал, байгалийн гамшигт байдал буурахад нөлөөлөх, байгалийн нөөцийг хэмнэх, нөөцийн хүртээмж сайжирна.
2	Боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчид	Үйлдвэрлэл, борлуулалт, экспорт нэмэгдэх, зах зээлээ тэлэх боломж бүрдэх ба ингэснээр цаашид тогтвортой хөгжих боломж нээгдэнэ.
3.	Боловсруулах үйлдвэрийн ажилтан, ажилчид	Ажлын байран дээрээ тасралтгүй суралцаж, ур чадвар, бүтээмж нь нэмэгдэж, тогтвортой ажиллах орчин нөхцөл бий болж, хувь хүний тогтвортой, үр бүтээлтэй ажиллах сонирхол дээшилж, орлого, ашигтай ажлын байртай байна.
4.	Жижиг, дунд үйлдвэрлэл /ЖДҮ/ эрхлэгчид	ЖДҮ эрхлэгчид кластераар хөгжих боломж бүрдэн, үйлдвэрлэл нэмэгдэж, орлого, ашиг өснө.
5.	Түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид	298 мянган малчдын үйлдвэрлэсэн түүхий эд нь эдийн засгийн эргэлтэд орж, орлого тогтворжиж, ашиг сайжирна.
6.	Судалгаа, шинжилгээний байгууллага	Зах зээлийн эрэлт хэрэгцээг судлах, тогтоох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын стандартад нийцүүлэх баталгаажуулах чадавх сайжирч, туршлага хуримтлуулан, гадаад зах зээлд өрсөлдөх чадвар нь сайжирч, хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд өсөж хөгжинө.
7.	Сургалтын байгууллага	Эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцөөр тасралтгүй хангах боломж бүрдэж үйл ажиллагаагаа өргөжүүлнэ.
8.	Мэргэжлийн холбоод	Үйлдвэрлэл, борлуулалт, экспортыг өсгөхөд чиглэсэн төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэнэ. Мэргэжлийн холбоод дэлхийн жишигт хүрч хөгжинө.

9.	Засгийн газар	Тогтвортой үйлдвэрлэл хөгжсөнөөр НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт-2030, Алсын хараа-2050 бодлогод туссан салбарын зорилт, зорилгууд хэрэгжинэ. Монгол Улсын болон олон улсын стандартад тэнцсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж, ажлын байр нэмэгдэж, хадгалагдаж, экспортод эзлэх хувь өссөнөөр эдийн засагт эерэг нөлөө бий болно.
----	---------------	---

1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Дор дурдсан тулгамдсан багц асуудал хөнгөн үйлдвэрлэлийн тэргүүлэх салбар болох мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд саад болж байна. Үүнд:

1.Эрх зүйн орчин хангалтгүй.

Хөнгөн үйлдвэрлэлийн салбарт хамаарах Хөрөнгө оруулалтын тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль, Инновацийн тухай хууль, Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хууль, Хөдөө аж ахуйн биржийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай зэрэг хууль тогтоомж үйлчилж байгаа хэдий ч хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэхэд тулгамдсан дээрх асуудлыг төрийн бодлогоор дэмжих шалгуур, ангилал, арга хэлбэрийг эдгээр хуулиудаар тусгайлан зохицуулаагүй.

Захиргааны ерөнхий хууль 2015 оны 6-р сарын 15 нд шинэчлэн батлагдсан ба хөнгөн үйлдвэрийн зарим салбарт олгож байсан урамшууллын бодлого, хөнгөн үйлдвэрийн инженер техникийн ажилтнуудыг давтан сургаж, мэргэшлийн зэрэг олгох журам хүчингүй болсноор эдгээр төрийн дэмжлэг эрхзүйн зохицуулалтгүй болсон.

Ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэлийн улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь хөнгөн үйлдвэрийн бусад салбараас харьцангуй их байдгийг хүлээн зөвшөөрч төр, засгийн нэлээдгүй баримт бичигт тэргүүлэх чиглэл, экспортын баримтжаатай, импортыг орлох гэж томьёолж төрөөс дэмжихээр тусгасан байдаг хэдий ч эдгээр үйлдвэрлэлийн бүтээмж, боловсруулалтын түвшин, хөгжилд тодорхой ахиц дэвшил гарахгүй байна. Өөрөөр хэлбэл, дотоод, гадаад зах зээлийн хэрэгцээ, шаардлагаас хоцрогдолтой хэвээр байна.

“Стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрөл батлах” тухай Улсын Их Хурлын 2008 оны 30 дугаар тогтоолоор угаасан ноолуур, Засгийн газрын 2008 оны 83 дугаар тогтоолоор Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтад ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэл тус тус хамрагдсан хэдий ч бусад салбараас ялгарах дэмжлэг өнөөг хүртэл тодорхойгүй хэвээр байна.

Түүнчлэн эдгээр салбарын бүтээгдэхүүнийг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэх, баталгаажуулах ажлуудыг хийж эхлүүлсэн хэдий ч дотоодын болон олон улсын зах зээлд сурталчлан таниулах, цар хүрээг нь тэлэхэд төрийн дэмжлэг, бодлогын уялдаа хангалттай бус байна.

2.Өртөг шингээгүй, хагас боловсруулсан байдлаар экспортод гардаг түүхий эдийн тоо хэмжээ буурахгүй байна.

- Түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоо бүрдээгүй, Хөдөө аж ахуйн биржийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, хуульд тусгагдсан зарим зохицуулалт хийгддэггүй.
- Экспортын татваргүй хагас боловсруулсан ноос, ноолуур арьс ширний экспорт өндөр байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспорт

Нэр төрөл	1997 он	1999 он	2005 Он	2010 он	2015 он	2020 он	2023 он
Бохир/ угаасан ноолуур (тонн)	824.6	799.5	381.3	3,103.9	4,988.2	6,339.8	5449
Самнасан ноолуур (тонн)	590.4	1,168.3	919.2	976.5	558.9	259.9	1,001

Угаасан ноолуурын экспорт 1997 он /824.6 тн/-той харьцуулбал 6.6 дахин (Хүснэгт 2) өссөн байна. Энэ нь экспортод гаргах ноолуурын экспортын татварыг Дэлхийн худалдааны байгууллага /ДХБ/-ын өмнө хүлээсэн үүргийн дагуу шатлан халсантай холбоотой.

Түүхий эдийн экспортын хэмжээг бууруулах чиглэлээр Хөдөө аж ахуйн биржээр бүртгэн түүхий эдийг арилжих, арьс ширний техникийн зохицуулалт батлах зэрэг арга хэмжээнүүдийг авч байсан хэдий ч эргэлтийн хөрөнгийн дутагдал, боловсруулах үйлдвэрийн чадавх сул болон улс төрийн нөхцөл байдал зэрэг хүчин зүйлээс хамаарч хэрэгжилт хангалтгүй байгаа нь ямар ч нөхцөлд дагаж тогтвортой мөрдөх хууль эрхзүйн орчин дутагдалтай байгааг нотолж байна.

Арьс, ширэн бүтээгдэхүүний экспорт

Барааны нэр	нэгж	Экспорт				Импорт			
		2022 он		2023 он		2022 он		2023 он	
		Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн
Боловсруулаагүй арьс шир	мян.ш	224.8	1,518.1	1,032.6	2,354.1	2.0	8.3	0.02	-
Боловсруулсан арьс шир	мян.дм	172,641.8	3,929.5	109,531.8	2,758.4	8,806.7	1,123.3	10,748.5	1,094.7
Арьс ширэн бэлэн бүтээгдэхүүн	-	-	483.6	-	605	-	8,084.1	-	8,427.1

Гүн боловсруулалтын дамжлагын хүчин чадал хангалтгүй, эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн нөхцөл муу, зээлийн хугацаа богино, барьцаа хөрөнгийн шаардлага өндөр байгаа нь сэргэх боломж олгохгүй байна.

Гүн боловсруулалтын үйлдвэрийг экспортын тоо хэмжээнээс хамаарсан дэмжлэг байдаггүй.

1. Хяналт зохицуулалтгүй гаднын орц бүхий бүтээгдэхүүний импортын нөлөөлөл

- Импортын ээрмэл, нэхмэл, боловсруулсан арьс, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, импортод тавих хяналтын тогтолцоо байхгүй.
- Импортын ижил төрлийн хувцас, бүтээгдэхүүн зах зээлд зохицуулалт, хяналтгүйгээр маш хямд үнээр борлуулагдаж байгаа нь дотоодын үйлдвэрийн барааны борлуулалт, нэр хүндэд нөлөөлж байна.
- Хэрэглэгч дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг таньж хэрэглэх боломжгүй, зөвхөн хуурамч шошго хаягт итгэсэн хэвээр байна.

3. Малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулахад чухал үүрэг бүхий ноос, ноолуур, арьс, ширний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх нөхцөл бүрдээгүй.

Дээр дурдсан эрх зүйн орчны нөхцөл байдлаас гадна малын тоо толгойн өсөлттэй холбоотой түүхий эдийн нөөц нэмэгдсэн хэдий ч түүхий эд үнэгүйдэж байгаа нь эдгээр түүхий эдийн боловсруулалтын түвшнийг ахиулах, экспортыг өсгөж, эдийн засгийг солонгоруулах, ажлын байрыг хадгалан нэмэгдүүлж, улс орны нийгмийн чухал хэсгийг авч явах, замаар улсын төсөвт орох валютын нөөцийг нэмэгдүүлэхэд тэргүүлэх ач холбогдол бүхий ноос, ноолуур, арьс ширний салбарыг хөгжүүлэхэд түлхэц дэмжлэг хангалтгүй байна.

Манай улс 2023 оны эцэст 64.6 сая толгой мал тоолуулсан бол энэ жилийн өвөлжилт, хаваржилтын хүндрэлтэй байдлаас шалтгаалан 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар 6.9 сая толгой мал, үүнээс 0.003 сая тэмээ, 0.38 сая адуу, 0.6 сая үхэр, 3.7 сая толгой хонь, 2.3 сая толгой ямаа тус тус хорогдоод байна.

Иймд хөнгөн үйлдвэрлэлийн салбарын экспортын гол бүтээгдэхүүн ноос, ноолуурын бэлтгэлийн хэмжээ буурч байгаатай холбогдуулан нөөцийг дотооддоо бүрэн ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар экспортын орлогыг бууруулах байх боломжтой юм.

Мөн сүүлийн жилүүдэд малын арьс, шир үнэгүйдэж хог дээр хаягддаг болсон. Энэ асуудлыг шийдвэрлэхэд төрийн бодлого зайлшгүй хэрэгтэй байна. (<https://www.montsame.mn/mn/read/235747>).

2. Ажиллах хүчний нөөцийн дутагдалд орсон үйлдвэрлэл

Хөнгөн үйлдвэрийн бүх салбарт нарийн мэргэжлийн ажилтан, инженер, техникийн ажилтны хангамж дутмаг, тогтвор суурьшил сул байгаа нь эрх зүйн орчин хангалтгүй байгаатай холбоотой байна.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш, эрдэмтдийн /Ж.Туяацэцэг, Д.Энхтуяа, Д.Батбаяр/ 2019 онд хийсэн судалгаанаас үзвэл:

- 1997-2019 оны хооронд буюу сүүлийн 10 жилд арьс, ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи мэргэжлээр 28, үүнээс жилд дунджаар 6 орчим оюутан төгсжээ. Харин загвар зохион бүтээлт мэргэжлээр 2005 оноос элсэлт авч эхэлснээс хойш нийт 93 хүн, 2018 онд 2, 2019 онд 3 оюутан тус тус төгссөн байна. Мөн хими технологи мэргэжлээр 2003-2018 оны хооронд элсэлт болон

төгсөлт байхгүй, харин технологич мэргэжлээр энэ хооронд 86 хүн төгссөн байна.

- 2020 онд ноос, ноолуурын үйлдвэрүүдэд хийсэн аттестатчиллаар төгсөгчдийн тоог үйлдвэрлэлийн хүчин чадалд шаардагдах эрэлттэй харьцуулахад хангалтгүй тоо гэдгийг судлаачид онцолсон байна.
- 2016 оны судалгааны явцад нэхмэлийн чиглэлээр эрэлт өндөртэй 28 төрлийн мэргэжлийн ажилтан дутмаг байгааг судлахад тухайлбал Улаанбаатар хивс ХХК-д эдгээрээс 13 мэргэжил нь дутагдалтай байсан байна.
- Түүнчлэн үйлдвэрийн цех тасгийн гол үйл ажиллагаа, технологийг чиглүүлж, удирдаж байдаг анхан шатны удирдлага болох мастерууд нь мэргэжлийн бус хүмүүс байгааг уг судалгаагаар тогтоогджээ.
- Хөнгөн үйлдвэрийн бүх салбарт инженер техникийн ажилтан /ИТА/, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх талуудын хамтын ажиллагаа сул, эрэлт хэрэгцээний дагуу бэлтгэдэггүй, ажиллах хүчний тогтвор суурьшил муу байгаа талаар сүүлийн 8 жил үйлдвэрлэл эрхлэгчдээс санал гарч байгаа хэдий ч арга хэмжээ авагдаагүй байдаг.
- ИТА-ыг мэргэшүүлж, мэргэшсэн, тэргүүлэх, зөвлөх инженерийг бэлтгэдэг тогтолцоо 2015 онд батлагдсан Захиргааны тухай хуульд тусгагдсан зохицуулалтаас хамаарч хүчингүй болсон нь дээрх тулгамдсан асуудлыг улам нэмэгдүүлж байна.

Уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын ажилтны цалин хөлс нь хөнгөн үйлдвэрийн цалингаас 2.2 дахин өндөр байгаа нь нөлөөлсөн гэж үзэх үндэслэлтэй.

Энэ байдалд дүгнэлт өгөхөд загвар зохион бүтээгч, нарийн мэргэжлийн инженер техникийн мэргэжилтнийг тэтгэлэгтэй болгох, үйлдвэрлэл өндөр хөгжсөн оронд сургах квотыг нэмэгдүүлэх тал дээр төрийн бодлого үгүйлэгдсээр байна

Хүний нөөцийг сургах, тогтвор суурьшилтай ажиллахад түлхэц болох цалин хөлс, урамшууллын шинэлэг арга, аргачлалыг ашиглах, бүтээгдэхүүний чанартай уялдуулсан системүүдийг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, урамшуулах тогтолцоо дутмаг байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Хэдийгээр хөнгөн үйлдвэрлэлийн салбарт хэд хэдэн хууль үйлчилж байгаа ч салбарын бодлогын баримт бичигт дурдсан тусгайлсан төрийн бодлогоор дэмжих шалгуур, ангилал, арга хэлбэрийг тодорхойлсон эрх зүйн орчин хэрэгтэй гэдэг нь асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоосон байдал, асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлөөс харагдлаа.

Малын гаралтай түүхий эдээр үнэ цэнэ, инновац шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эдийн засгийн эргэлтэд оруулах, Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий гэж бодлогын баримт бичиг, судалгаагаар тогтоогдсон салбарын үйлдвэрлэл, экспортыг дэмжих, импортын ижил нэрийн бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах, төрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх болон төр, төрийн бус, байгууллага, үйлдвэрлэгчдийн эрх, үүргийг хуулийн хүрээнд тодорхой болгох шаардлагатай нь тогтоогдсон. Энэ талаар салбарын эрдэмтэн, судлаачид, мэргэжилтнүүд, мэргэжлийн холбоод ч удаа дараагийн хэлэлцүүлэг, уулзалтын үеэр уламжилсаар ирсэн.

Экспортын бүтээгдэхүүний бүтцэд хийсэн дүн шинжилгээгээр экспортын барааны 97 хувь нь анхан шатны боловсруулалт хийсэн уул уурхайн болон технологийн агууламж багатай бүтээгдэхүүн байна. Үүн дотроос хөнгөн үйлдвэрийн тэргүүлэх салбар болох ноос, ноолуур, арьс, ширний экспорт 2023 онын байдлаар дөнгөж 3.0 хувийг эзэлж байгаа нь түүхий эдийн нөөцтэйгөө харьцуулахад маш чамлалттай үзүүлэлт юм.

Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Ерөнхий зорилго: Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих;

Зорилт: Энэ тогтоолын зорилт нь үнэ цэнэ шингэсэн, байгаль орчинд ээлтэй мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах үнэ цэнэ шингэсэн ноос, ноолуур, арьс ширний тэргүүлэх ач холбогдолтой үйлдвэрлэлийг олон улсын жишигт нийцүүлэх, эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Асуудлыг зохицуулах хувилбарууд

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.“тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Дээр тодорхойлсон асуудлууд нь одоогийн хүчин төгөлдөр хуульд зохицуулалт байхгүйгээс үүдэн гарч байгаа тул “тэг” хувилбар оновчгүй нь илэрхий. Асуудал байсаар байна. Зорилго хангагдахгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч сөрөг үр дагавар нэмэгдэнэ. Түүхий эдийн экспорт буурахгүй, харин ажлын байрны тоо буурна. Түүхий эд үнэгүйднэ.	Үр ашиг байхгүй.
2.Хэвлэл, мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;	Төсвийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон боловч, сурталчлан таниулах ажлыг хүчтэй, зөв хийж чадвал стандартын шаардлага хангасан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, салбарт шаардлагатай	Сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажилд зардал гаргаснаар чанар, стандартын шаардлага хангасан ээлтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ. Залуучуудын салбарт ажиллах сонирхлыг өдөөж чадна.	Дээр дурдсан зарим асуудлыг шийдвэрлэхэд тодорхой үр дүнтэй.

	хүний нөөцийг татахад нөлөө үзүүлнэ.	Гэхдээ дээр дурдсан асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломжгүй.	
3.Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;	Төрөөс ноос, ноолуур, арьс, ширний салбарыг дэмжих бодлого, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр зохицуулалт хийгдэж байгаа боловч үйлдвэрлэл, экспортын бүтцэд дорвитой өөрчлөлт гараагүй өнөөгийн дүр зураг хэвээр үргэлжилнэ.	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Ажиллах хүчний дутагдалтай байдал, импортын барааны нөлөөлөл үргэлжилнэ. Малын гаралтай түүхий эд эдийн засгийн эргэлтийн хувь хэмжээ бага хэвээр байна.	Үр ашиггүй.
4.Төрөөс санхүүгийн интервенц хийх	Санхүүгийн интервенц хийх замаар тухайн асуудлыг шийдвэрлэх боломжгүй.	Зардал их хэмжээгээр шаардагдана. Үйлдвэрлэл эрхлэгчдийн бэлэнчлэх сэтгэлгээг нэмэгдүүлнэ. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгаж чадах эсэх нь тодорхойгүй.	Үр ашиггүй.
5.Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;	Мэргэжлийн холбоодыг чадавхжих боломжтой ч, тэдний гүйцэтгэх хянах, баталгаажуулах үйл явц нь өндөр үнэтэй тул үйлдвэрүүд баталгаажуулалт хийлгэх сонирхол багатай байна.	Нөхцөл байдал дорвитой өөрчлөгдөхгүй.	Үр ашиг бага.
6.Захиргааны шийдвэр гаргах	Тусгайлсан эрх олгосон хууль зүйн зохицуулалт байхгүй учраас Захиргааны ерөнхий хуулийн 11 болон 59 дүгээр зүйлд заасан шийдвэр гаргах боломжгүй.	Зардал гарахгүй, үр өгөөж байхгүй.	Үр ашиггүй.
7.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.	Хөнгөн үйлдвэрийн салбарын тэргүүлэх ач холбогдол бүхий үйлдвэрлэл (ноос, ноолуур, арьс, шир)-ийг дэмжих тухай тогтоолын төслийг боловсруулах замаар тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зохицуулалтуудыг тусгаж	Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой. Олон улсын стандарт, чанарын шаардлага	Үр ашигтай.

	цогцоор нь шийдвэрлэх боломжтой. Мэргэжилтэй ажилтны хэрэгцээ хангагдана.	хангасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт өснө. Гадаад валютын урсгал, татварын орлого нэмэгдэнэ. Ажлын байр нэмэгдэх ба хадгалагдана.	
--	--	--	--

Тэг хувилбар, иргэд, олон нийтийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенц хийх замаар тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт үүсээд байгаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй юм. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх хувилбар нь тулгамдаад байгаа асуудлыг цогцоор нь шийдвэрлэхгүйгээс гадна шаардагдах санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэгийг үзүүлэх боломжгүй тул тохирох хувилбар биш. Захиргааны шийдвэр гаргах эрх олгосон зохицуулалт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн орчноор олгогдоогүй тул энэ хувилбараар асуудлыг шийдвэрлэх боломж байхгүй.

Харин асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дэвшүүлсэн зорилтод хүрэхийн тулд хөнгөн үйлдвэрийн салбарын тэргүүлэх ач холбогдол бүхий үйлдвэрлэл (ноос, ноолуур, арьс, шир)-ийг дэмжих тухай хууль, тогтоолын төслийг боловсруулах нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хамгийн үр нөлөөтэй хувилбар гэж үзлээ.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

4.1. “Хүний эрхэд үзүүлэх нөлөө”

Уг тогтоол нь хүний эрхийн зөрчил, хүний эрхийг хязгаарласан, мөн жендерийн тэгш байдлыг зөрчих зохицуулалт агуулаагүй, тэгш хандлагатай. Манай улсын мал аж ахуйн үндсэн түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хүн амыг тогтвортой орлоготой болгох, ажилгүйдлийн түвшнийг бууруулах шаардлага зүй ёсоор тулгарч байгаа бодит нөхцөл байдал, судалгаанд үндэслэн гарч буй тогтоол юм. Үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд үйлдвэрлэл, экспорт нэмэгдсэнээр үр ашигтай ажиллаж байгаа ч олон хүнийг ажлын байраар тогтвортой хангах, нөгөө талаас хэрэглэгчдийг хувьд чанартай бараа, бүтээгдэхүүнээр тогтвортой хангах үүрэг хүлээх болно. Энэ нь иргэдийн эдийн засгийн эрхүүд хангагдах боломжийг бүрдүүлж Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

4.2. “Эдийн засагт үзүүлэх нөлөө”

Уг тогтоол батлагдсанаар стратегийн тэргүүлэх үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа чадавхижиж, бүтээгдэхүүн нь олон улсын стандарт, чанарын шаардлага хангаснаар өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт өсөж, гадаад валютын нөөц болон улсын төсөвт орох татварын орлого өсөх боломж бүрдэнэ.

Түүнчлэн хууль, тогтоомжоор төрийн дэмжлэгийг хэрхэн шийдвэрлэхээс шалтгаалж төсөвт нэмэлт зардал үүсэж болзошгүй ч эргээд нөхөх боломж бүрдэнэ.

4.3. “Нийгэмд үзүүлэх нөлөө”

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин эрх зүйн орчныг бүрдүүлж, соён гэгээрүүлэх ажлыг эрчимтэй хийснээр ажлын байр шинээр бий болж шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт технологийг даган хүний нөөцийн чадвар сайжрах тул нийгэмд эерэг нөлөөтэй.

4.4. “Байгаль орчинд үзүүлэх нөлөө”

Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг түлхүү дэмжиж өгснөөр байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ.

4.5. “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх”

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, зохицуулалтын хүрээнд нийцүүлэн хууль, тогтоомжийн өөрчлөлтийн төсөл боловсруулагдсан болно. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын нийт гэрээтэй тогтоолын төслийн агуулга нь зөрчилдсөн зүйл байхгүй болно.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Тогтоолын төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлахад хөнгөн үйлдвэрийн салбарын тэргүүлэх ач холбогдол бүхий үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэхэд тулгарч буй а/ өртөг шингээгүй, хагас боловсруулсан байдлаар экспортод гардаг, б/ хяналт зохицуулалтгүй импортын нөлөөлөл, в/малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулахад чухал үүрэг бүхий ноос, ноолуур, арьс, ширний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, г/ажиллах хүчний нөөцийн дутагдалд орсон үйлдвэрлэл, д/эрх зүйн орчин хангалтгүй гэсэн таван үндсэн асуудлыг шийдвэрлэхэд тэг хувилбар, сурталчилгааны ажил өрнүүлэх, хувийн хэвшлээр зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх, зах зээлийн хэрэгслийг ашиглан дэмжих, санхүүгийн интервенц хийх

болон захиргааны шийдвэр гаргах хувилбаруудаас илүүтэйгээр хууль, тогтоолын төсөл боловсруулах хувилбар нь хамгийн үр дүнтэй, оновчтой болох нь харагдлаа.

Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг дараах хүснэгтэд зааснаар үзүүлэв.

Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө					
Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар	
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх				
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	-	Ялгаварлан гадуурхалтыг хориглож буй зохицуулалт агуулаагүй.	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	-	Үгүй	Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх зохицуулалт агуулаагүй.	
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	-	Хуулийн төслөөр тодорхой бүлгийн эмзэг байдлыг бус үйлдвэрлэл эрхлэгчдийн эрсдэлт байдлыг бууруулахад чиглэсэн зохицуулалт хийгдэнэ.	
	1.2. Оролцоог хангах				
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	-	Салбарын яамны холбогдох албан тушаалтнууд, үйлдвэрлэл эрхлэгчид, салбарын холбоод, эрдэмтэн судлаачид, үйлдвэрлэгчдийн саналыг тусгаж ажиллав.	
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	-	Үйлдвэрлэл эрхлэгчид, салбарын холбоод, дээд сургууль, мэргэжил сургалтын төв, малчид, хоршоод, импортлогч, экспортлогч, худалдаа эрхлэгч	
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	-	Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор баталгаажуулсан иргэдийн эдийн засгийн эрх чөлөөг хангахад нөлөө үзүүлнэ. Орлого тогтвортой болж, өснө.	
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн	Тийм	-	Хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид зөрчилдөх зүйл байхгүй.	

	механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх			
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	-	Хуулийг хэрэгжүүлэх явцад хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцно.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	-	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	-	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	-	• Үйлдвэрлэл эрхлэгч • Түүхий эд бэлтгэн нийлүүлэгч, малчид • Баталгаажуулалтын байгууллага худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	-	Малчид, үйлдвэрлэл эрхлэгчид, ажилчид үүсэж болох эрсдэлийг бууруулах харилцааг агуулна.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	-	Хуулийн төсөл нь малын гаралтай түүхий эдийг эдийн эргэлтэд оруулж үнэ цэнэ шингэсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ажлын байр олноор нэмэгдүүлэх, хадгалах, орлого нэмэгдэх нийгмийн харилцааг агуулна.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	-	Үгүй	Тусгайлсан хуулиар зохицуулалттай тул дахин зохицуулах шаардлагагүй
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	-	• төрийн байгууллага • үйлдвэрлэл эрхлэгчид • түүхий эд бэлтгэн нийлүүлэгч
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	-	Үгүй	Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуультай нийцэж байгаа тул дахин зохицуулах шаардлагагүй.

тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	-	Жендерийн тэгш байдлыг ханга тухай хуультай нийцэж байгаа.
------------------------------	---	------	---	--

Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	-	Үгүй	Энэ чиглэлээр зохицуулалт агуулаагүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	-	Үйлдвэрлэлийн өсөлтийг дагаад зардал өсөх боловч, ашиг нэмэгдэх тул нөхөх боломжтой.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	-	Үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэхэд чиглэсэн дэмжлэг авна.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	-	Түүхий эдээ тогтвортой авах боломж бүрдэх
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх			
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	-	Тодорхой хэмжээний нэмэлт зардал гарах хэдий ч, үр өгөөж илүү.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах тэмдэг олгох зохицуулалт тусгана.
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	-	Дэмжинэ
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	-	Мэдлэг шингэсэн, инновац, ногоон технологийг нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг дэмжинэ
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	-	Дотоодын зах зээлийг ашиглах боломж нэмэгдэнэ
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	-	Хуурамч бүтээгдэхүүнээс хамгаалагдахад эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	-	Ажлын байр хадгалагдаж, өрхийн орлого өснө
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	-	Тодорхой бүс нутагт ажлын байр нэмэгдэнэ

	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	-	Хамтран хөгжих боломж бүрдэнэ
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	-	Үйлдвэрлэл, экспорт нэмэгдэхийн хэрээр улсын төсөвт орох татварын орлого нэмэгдэнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	-	Үгүй	Шинээр байгууллага байгуулахгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	-	Эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийн байдалд зөрөг нөлөө үзүүлэх болно.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	-	Хөрөнгө оруулалтын нөхцөл сайжирч, тогтвортой хөгжлийг дэмжинэ
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	-	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй

Хүснэгт 1. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	-	Олон ажлын байр нэмэгдэнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	-	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй, ажлын байр нь хадгалагдана.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжилтэй ажилтан

				бэлтгэх сургалтын тоо өснө
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	-	Түүхий эд, бүтээгдэхүүний чанар сайжирна
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	-	Үгүй	Үгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	-	Үгүй	Ажилтны цахим мэдээллийн санг бүрдүүлнэ.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	-	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажлын байр нэмэгдэнэ.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	-	Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэг нөлөөлнө
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	-	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	-	Тийм	Уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхлэх өв соёл өвлөгдөн үлдэнэ.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

Хүснэгт 2. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй	Байгальд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжсэнээр агаарын бохирдлыг

				бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Эрчим хүчний хэмнэлттэй ногоон дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Усыг хэмнэлттэй зарцуулах ногоон дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь	Тийм	-	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

сэргээгдэхгүй байгалийн баялаг	алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх			
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	-	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй..

ЗУРГАА.ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Орчин цагт бизнес нь зөвхөн санхүүгийн хувьд ашигтай байх нь хангалтгүй болжээ. Учир нь нийлүүлэлтийн болон нэмүү өртгийн сүлжээндээ байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх, хүний эрхийн эрсдэлийг бууруулах, улмаар арилгахыг үндэстэн дамнасан корпорацууд, экспортын бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс шаардах болсон. Тухайлбал, бизнесийн нийлүүлэлтийн сүлжээнд хүний эрх, байгаль орчныг хамгаалах зэрэг тогтвортой хөгжлийн зарчмуудыг мөрдүүлэх зайлшгүй шаардлагыг Их долоогийн (G7) дээд хэмжээний 2015 оны уулзалтын тунхаг бичигт онцлон тэмдэглэжээ. Учир нь байгаль орчны бохирдол нь хүний амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, өндөр наслах зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг ноцтой зөрчихөөс гадна хувь хүний суурь чадавх (эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлт)-д урт хугацааны туршид сөрөг нөлөө үзүүлдгээрээ хор уршиг ихтэй гэж үздэг. Азийн орнуудаас Япон улс “Хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээнд хүний эрхийг хүндэтгэх удирдамж”-ийг батлан 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна. Уг удирдамжийг Япон улсад үйл ажиллагаа эрхэлж буй бизнесүүд төдийгүй тэдгээрийн нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талууд ч мөн адил дагаж мөрдөх үүрэгтэй.

Европын холбоо нь бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалахад баримтлах зарчмуудыг зохицуулсан эрх зүйн баримт бичгийг ойрын хугацаанд батлахаар ажиллаж байна. Энэ хүрээнд жишээ нь ХБНГУ-д хүний эрхийн зөрчил гаргасан бизнесийг нэг зуун мянгаас найман сая еврогоор торгохоор хуульчилсан.

Дэлхийн хэмжээнд зах зээлийн эрх зүйн зохицуулалт ийнхүү чангарахын зэрэгцээ худалдан авагч, хэрэглэгчдийн хандлагад ч томоохон өөрчлөлт гараад байна. Тухайлбал, хүмүүсийн байгаль орчны эрүүл байдалд санаа зовних нь сүүлийн таван жилд 16%-аар өссөн бөгөөд Ковид-19 халдварт өвчнөөс хойш энэ байдал огцом нэмэгджээ. Байгаль орчны өсөн тэлж байгаа хямралын тухай илүү их мэддэг болсон энэхүү шинэ хандлагыг “эко-сэрэлт” гэж Дэлхийн зэрлэг байгаль хамгаалах сангаас нэрлэсэн байна.

Ийнхүү дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад эерэг хувь нэмэр оруулах хүсэл нь байгальд ээлтэй арга замаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдаж авахыг эрмэлзэхэд хүргэсэн анхдагч шалтгаан юм. Жишээ нь, дэлхийн хүн амын 80%-ийг хамруулан 54 оронд 27 хэлээр 2016-2020 оны хооронд судалгаа явуулж, байгальд ээлтэй арга замаар үйлдвэрлэсэн нь баталгаатай бүтээгдэхүүнийг худалдан авч байгаа шалтгааныг тодруулахад: 30% нь байгаль орчноо сайжруулах, 23% нь хог хаягдлыг багасгах, 22% нь хүлэмжийн хийн ул мөрийг бууруулах, 17% нь мал амьтны эрх ашгийн төлөө гэсэн бол зөвхөн 7% нь л нийтийн хандлагыг даган тогтвортой бүтээгдэхүүн авдаг гэжээ.

“Европын супермаркет” сэтгүүлд дурдсанаар, орчин үеийн хэрэглэгчдийн худалдан авалтын шийдвэрээс дараах хандлага ажиглагдаж байна. Үүнд: Байгаль орчинд ээлтэй амьдрах хүсэл, хандлага нэмэгдэхийн хэрээр бүтээгдэхүүний нийлүүлэлтийн болон өртгийн сүлжээ бүхэлдээ байгаль орчинд ээлтэй байх шаардлагатай болсон. Тухайлбал, Европын 5,000 хэрэглэгчдийн дунд 2018 онд явуулсан судалгаанд оролцогчдын 40% нь тэдний хэрэглэж байгаа хүнс, ундаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлээгүй байхыг чухалчилснаас гадна дэлхий нийтэд тулгараад байгаа уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд бизнесүүд хувь нэмрээ оруулах ёстой гэж үзжээ. Тэр дундаа байгаль орчныг хамгаалах (88%), уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, ядуурлыг бууруулах (85%)-д бизнесүүд түлхүү оролцох ёстой гэсэн байна. Өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орны хэрэглэгчдийг хамруулсан “Хэрэглэгчдийн дуу хоолой-2021” судалгаанд оролцогчдын 35% нь тогтвортой арга хэлбэрээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авахыг илүүд үзнэ гэжээ.

Хог хаягдал: Байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулсан эсэх, хог хаягдалгүй дахин ашиглах боломж, хүлэмжийн хийн ялгаралтад үзүүлэх нөлөө зэрэгт хэрэглэгчид ач холбогдол ихээр өгөх болсон. Ойрх дорнодын Арабын булангийн зургаан орны хэрэглэгчдийн дунд 2020 онд явуулсан судалгаагаар 80% нь тогтвортой амьдралын хэв маягийг сонгоход бэлэн, 56% нь тогтвортой амьдралын хэв маягийг сонгох нь зайлшгүй шаардлага гэж хариулжээ.

Ёс суртахуун: Тухайн бүтээгдэхүүний гарал үүсэл, үйлдвэрлэсэн арга хэлбэр, сэдэл, түүх, нийлүүлэлтийн болон өртгийн сүлжээний туршид хүний эрх зөрчигдсөн эсэхтэй холбоотой мэдээлэлд ач холбогдол өгөх болсон. Европын 5,000 хэрэглэгчдийн дунд 2018 онд явуулсан судалгаанд оролцогчдын 61% нь хүний эрх зөрчигдсөн эсэх, амьтанд ээлтэй эсэхийг; 30% нь бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон нийлүүлэгчийн ажилчид шударга цалин хөлс авдаг эсэхийг мэдэхийг хүссэн байна.

Цахимжилт: Технологийн дэвшлийн нөлөөгөөр бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг цахим сувгаар түлхүү авах болсон бөгөөд энэ хэрээр бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, цар хүрээ өргөжсөөр байна.

Дээрх шинэ хандлагад нийцүүлэх үүднээс бизнесийн олон салбар хариуцлагатай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд түүхий эдийн худалдан авалтаас эцсийн бүтээгдэхүүн гаргах хүртэлх бүх шат дамжлагатаа байгаль орчны асуудлыг чухалчилж үзэх боллоо.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөгжилд хөнгөн үйлдвэр голлох үүрэг гүйцэтгэсэн. Дэлхийн ноолуурын зах зээлд тэргүүлэгч орон БНХАУ дээрх чиг хандлагад нийцүүлэн олог улсын стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх, дэмжих чиглэлд эрчимтэй арга хэмжээ авч байна.

Хөнгөн үйлдвэрлэлийн салбар нь олон хүний ажлын байр шингээдэг онцлогтой тул хүн ам олонтой ялангуяа зүүн өмнөд азийн орнуудад тус салбар хөгжиж байна.

Зарим улсын туршлагаас харвал:

- Их британ улс нь гаалийн өндөр татвар, их хэмжээний татаас, патентийн хуулиар шинэ санааг хамгаалснаар хүчирхэг орон болсон түүхтэй.

- Сингапур улс нь гадаадын хөрөнгө оруулагчдыг урьж байсан ч стратегийн гэж үздэг салбаруудаа олон улсын корпорациудыг татахын тулд ялангуяа тодорхой салбаруудад чиглэсэн дэд бүтэц, боловсролд төрөөс хөрөнгө оруулж нилээд хэмжээний татаас өгч байсан.
- Солонгос, Вьетнам зэрэг орнуудад ч дотоодын орцын шаардлагыг хатуу тавьснаар үйлдвэрлэл нь эрчимтгэй хөгжжээ.

Мал аж ахуй, түүнээс гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэл дорвитой хөгжихгүй байгаа шалтгаан нь манай улсын авч хэрэгжүүлж байгаа урамшууллын бодлого оновчтой бус, дэмжлэг, хяналт сул, хариуцлага тооцох механизм тодорхойгүй, түүхий эд бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцоо бүрдээгүй зэрэгтэй холбоотой юм.

ДОЛОО.ЗӨВЛӨМЖ

Тулгамдаад байгаа асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, төрийн дэмжлэгийн эрх зүйн орчныг сайжруулах, түүхий эдийн чанар, байгальд ээлтэй байдлыг эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар дамжуулан олон улсын хэрэглэгчийн эрэлт шаардлагад нийцүүлэн баталгаажуулах, үнэ цэнийг нь нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхдээ ногоон хөгжлийн болон бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах, хүний нөөцийн эрэлт хэрэгцээг хангах, тогтвор суурьшлыг сайжруулахад хувийн хэвшлийн бүтээлч санал санаачилга, оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд Засгийн газрын 2008 оны 83 дугаар тогтоолоор Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтад орсон ноос, ноолуур, арьс ширний тэргүүлэх үйлдвэрлэлийг дэмжин тогтвортой хөгжүүлэх үзэл санаатай бүрэн нийцэж байгаа юм.

---oOo---

**МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙГ БОЛОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоол /цаашид “тогтоолын төсөл” гэх/-ын төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу үнэлсэн болно.

Тогтоолын төслийг аргачлалд заасны дагуу дараахь үе шаттай хийлээ.

1. Ерөнхий зүйл
2. Шалгуур үзүүлэлтийг сонгох
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**ХОЁР.ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ,
ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ тогтоолын төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Гарах зардал
4. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан тогтоолын төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, тогтоолын төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь тогтоолын төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэллээ.

Энэхүү үнэлгээг хийхдээ тогтоолын төслийн үзэл баримтлалтай танилцаж, тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, тогтоолын төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 30, 35, 36 дугаар зүйл болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд тогтоолыг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд тогтоолын төслийг бүхэлд нь сонгон авлаа.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийг бүхэлд нь Үндсэн хууль холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн үзэл баримтлалд тусгасан тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тогтоолын төслийн зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс тогтоолын төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон тогтоолын төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ. Тогтоолын төслийн үзэл баримтлалд дурдсанаар:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 3.5-д “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 4.2.2-т “хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” гэж, 4.5.1-д “судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан, гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.9-д “Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 1.15 дахь хэсгийн 139-д Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулахаар тус тус заасан.

Хөнгөн үйлдвэрлэлийн салбарт хамаарах Хөрөнгө оруулалтын тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацын тухай, Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай, Хөдөө аж ахуйн биржийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай зэрэг хууль үйлчилж байгаа хэдий ч хөнгөн үйлдвэрийн тулгамдсан асуудлыг төрийн бодлогоор дэмжих шалгуур, ангилал, арга хэлбэрийг дээрх хуулиудаар тусгайлан зохицуулаагүй байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2022 онд 43.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 8.6 (24.4 хувиар) их наяд төгрөгөөр, 2018 оноос 16.3 (59.7%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Үүнд боловсруулах үйлдвэрлэлийн салбар 2.8 (25.6%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хөнгөн үйлдвэрлэлийн салбар 2023 онд нийтдээ 484.8 сая ам долларын экспорт хийсний 93 хувь буюу 451.2 сая ам долларыг нэхмэлийн буюу ноос, ноолуурын салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

Манай улс дэлхийн ноолуурын нөөцийн 40 гаруй хувийг бэлтгэх нөөцтэй хэдий ч нэмүү өртөг бүтээх, өндөр ашиг шим хүртэх стратегийн бүтээгдэхүүнээсээ олох боломжит орлогоо алдсаар байна.

Манай улс Дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүргийн дагуу экспортод гаргах түүхий болон угаасан ноолуур экспортын татварыг шатлан халсан холбоотойгоор угаасан ноолуурын экспорт 1997 онтой харьцуулбал 6.6 дахин өссөн байна.

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд байгуулсан ноос, ноолуур экспортлох үеийн мал эмнэлэг, ариун цэвэр хорио цээрийн протоколын хүрээнд манай улсаас тус улсад түүхий бус угаасан ноос, ноолуур экспортлох болсноор манай улс жилд дунджаар 1.2 сая м3 цэвэр усыг ашиглаж, төдий хэмжээний бохир усыг байгаль орчинд гаргаж, дорвитой нэмүү өртөг шингээж чадахгүйгээр нийт түүхий эдийнхээ 70 гаруй хувийг зөвхөн угаагаад тус улсад экспортолсоор байна.

Манай улс жилдээ 18 сая ширхэг арьс, шир бэлтгэх нөөцтэй хэдий ч өнөөгийн байдлаар арьс ширний нөөцийн 30 хүрэхгүй хувийг үндэсний боловсруулах үйлдвэрт нийлүүлэгдэж байна. Тухайлбал жилд 3.4 сая ширхэг арьс ширэнд хагас боловсруулалт, 1.2 сая ширхэг арьс ширэн гүн боловсруулалт, нийт 4.6 сая ширхэг нь боловсруулагдаж, 13.4 сая ширхэг арьс ширийг боловсруулж чадахгүй байна.

Сүүлийн жилүүдэд үндэсний боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эд бэлтгэлд зориулан хөнгөлөлттэй зээл олгож байгаа боловч банкны шалгуур өндөр, барьцаа хөрөнгийн дутагдалтай байдал, эргэн төлөлтийн хугацаа бага зэргээс шалтгаалан хангалттай хэмжээний зээлээ авч чадахгүй байна.

Нөгөөтээгүүр хөрөнгө оруулалтын чиглэлээр бага хүүтэй, урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл гарахгүй байгаагаас шалтгаалан дэвшилтэт технологи бүхий, шинэ тоног төхөөрөмжийг худалдан авч чадахгүйгээс хуучин тоног төхөөрөмж оруулж ирэх явдал түгээмэл байна. Үйлдвэрлэлийн бүтээмж бага, хүчин чадлын ашиглалт доогуур, өртөг зардал өндөр байдгаас ижил төрлийн импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөж чадахгүй байна.

Энэ нь үйлдвэрлэл дорвитой хөгжихгүй байхад нөлөөлж байна.

Манай улс чөлөөт зах зээлд шилжсэнээс хойш түүхий эд бэлтгэлийн тогтолцоо бүхэлдээ байхгүй болсон нь түүхий эд үнэгүйдэх, мал аж ахуй эрхлэгчдийн бэлтгэж буй түүхий эд нь үйлдвэрлэлийн шаардлага хангахгүй байдлыг үүсгэж байна.

Үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах зорилгоор хонь, тэмээний ноос, арьс, ширэн түүхий эд бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгож эхлээд 10 гаруй жил болж байгаа хэдий ч түүхий эдийн чанар сайжирч, үнэ цэнэ нь өсөхгүй байгаад дүгнэлт хийж, урамшууллын бодлогыг зөв, оновчтой зүйлд чиглүүлэх шаардлагатай байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 2021 оны судалгаанаас үзвэл бог малын арьсанд хачиг, хамууны гэмтэл үүнээс гадна шивээний гэмтэл, харин адууны ширэнд тамганы сорви их байсан байна.

Иймд бог малыг бүрэн эрүүлжүүлэх, мал сүргийнхээ арьсанд механик гэмтэл үүсгэхгүй байх талаар малчдад сургалт хийх шаардлагатай байна.

Түүнчлэн 2025 оноос хэрэгжиж эхлэх махны техникийн зохицуулалттай уялдуулан мал төхөөрөх үйлдвэрүүд, арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг сайжруулах замаар арьс ширний нядалгааны үеийн гэмтлийг бууруулах боломжтой юм.

Мөн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн шаардлагыг хангасан байх, нийлүүлэлт хийх зорилтот зах зээл нь тодорхой байх нь нэн чухал байдаг. Гэтэл ижил нэрийн барааны импорт болон худалдааны хяналтын тогтолцоо бэхжээгүй байгаагаас дотоодын зах зээл хамгаалагдахгүйд хүрч улмаар нэг талаас хэрэглэгчдийг төөрөгдүүлж, иргэд эдийн засгийн хувьд хохирч байгаа бол нөгөө талаас энэ байдал нь үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд ч саад болж байна.

Иймээс үнэ цэнэ шингэсэн, өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үйл явцыг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн баталгаажуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд гаднын томоохон худалдан авагчид түүхий эд бүтээгдэхүүнийг худалдан авахдаа чанар, түүнээс гадна байгаль орчинд ээлтэй байх, мал, амьтны тавлаг байдлыг хангасан байх гэдэг шаардлагыг ихээхэн тавьдаг болсон.

Эрс, тэс уур амьсгалтай, бэлчээрийн мал аж ахуйгаа хадгалан үлдсэн манай улсын хувьд өөрийн орны онцлог соёл, монгол малчдын байгаль орчин, мал ахуйгаа хайрлан хамгаалж, уламжлан ирсэн өвөрмөц арга ажиллагааг орчин цагийн органик үйлдвэрлэл, мал, амьтны эрх чөлөөний нийтлэг зарчимтай уялдуулан тэдний шаардлагад нийцсэн үнэ цэнэтэй, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлээ тэлэх шаардлагатай байна.

Түүнчлэн хөнгөн үйлдвэрийн бүх салбарт мэргэшсэн инженер, техникийн ажилтнууд болон мэргэжилтэй ажилчин бэлтгэх тогтолцоо төлөвшөөгүй, ажиллах хүчний тогтвор суурьшил муу байна.

Ноос, ноолуурын үйлдвэрүүдэд 2020 онд хийсэн аттестатчиллаар төгсөгчдийн тоог үйлдвэрлэлийн хүчин чадалд шаардагдах эрэлттэй харьцуулахад хангалтгүй байсан, үйлдвэрийн цех тасгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж буй мастерууд нь мэргэжлийн бус байгааг онцолсон байна.

Хүний нөөц дутагдалтай байгаа нь салбарын ажилтны цалингийн дундаж бусад салбар тухайлбал, уул уурхайн салбарт ажиллаж буй ажилтнуудтай харьцуулахад бага байгаатай холбоотой юм. Хүний нөөцийг сургах, тогтвор суурьшилтай ажиллахад түлхэц болох цалин хөлс, урамшууллын шинэлэг арга, аргачлалыг ашиглах, бүтээгдэхүүний чанартай уялдуулсан системийг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, урамшуулах тогтолцоо дутмаг байна.

Нөгөөтээгүүр шинээр батлагдсан зарим хууль тогтоомжийг дагаад хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжилд чухал нөлөө үзүүлж байсан хөнгөн үйлдвэрийн салбарын мэргэшсэн, зөвлөх, тэргүүлэх инженерүүдийг сурган баталгаажуулж, гэрчилгээжүүлэх зохицуулалт орхигдсон нь тус салбарын тулгамдсан асуудлыг улам нэмэгдүүлсээр байна.

Эдгээр тулгамдаж буй асуудал нь өөр хоорондоо харилцан уялдаатай байх бөгөөд нэгийг нь шийдвэрлэснээр үр дүн гарах бус цогцоор шийдвэрлэх нь зүйтэй байна.

Дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагыг үндэслэн мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор “Малын гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

Тогтоолын төслийн тогтоох хэсэгт 1 дэх заалтад “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар батлах ба 2 дахь заалтад Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих “Цагаан алт” хөдөлгөөнийг өрнүүлж, дараах арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгахыг заасан ба 3 дахь заалтаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн санхүүжилтийг “Цагаан алт” хөдөлгөөний хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээтэй уялдуулан ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгож, 4 дэх заалтаар тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг жил бүрийн хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлж, хэрэгжилт, үр дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд тус тус даалгасан нь тогтоолын төслийн үзэл баримтлалаар тавьсан зорилгыг биелүүлэх боломжтой гэж үзэж байна.

3.2. “Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 30, 35, 36 дугаар зүйл болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд тогтоолыг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд тогтоолын төслийг бүхэлд нь сонгон авлаа.

Тогтоолын төслийн тусгасан байдал нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 35, 36 дугаар зүйлд нийцсэн байна.

3.3. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийг аргачлалд тусгасан тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог тогтоохын тулд тогтоолын төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн талаар аргачлалын 4.10 дахь заалтад заасан шалгах асуултад хариулах байдлаар үнэлгээг хийлээ:

№	Асуулт	Хариулт	Дүн шижилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Шаардлага хангасан
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	-	Улсын Их Хурлын тогтоолын төсөлд асуултад дурдсан хэсэг байхгүй болно
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	-	Улсын Их Хурлын тогтоолын төсөлд асуултад дурдсан хэсэг байхгүй болно

4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Нийцэж байна
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Давхардсан зохицуулалт байхгүй
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Үгүй	Тогтоолын төслийг хэрэгжүүлэх чиг үүрэг нь Засгийн газарт байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй	Аюулгүй байдалтай холбоотой учир төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжгүй
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчил илрээгүй
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	-	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй

15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Үгүй	Хууль тогтоомжийн тухай хуулийн 35.1.-д “Монгол Улсын Их Хурлын тогтоол” /цаашид “Тогтоол” гэх/-ын төсөл дараах шаардлагыг хангасан байна. 35.1.3-т “хариуцлагын хэм хэмжээ заахгүй байх” гэж заасан

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд тогтоолын төслийн зүйл заалт хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн зохицуулалт байхгүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үнэлгээний ажлын явцад тогтоолын төслийн харилцан уялдаа, тогтоолын төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тогтоолын төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох зорилгын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, уг асуудлын хүрээнд хийгдсэн судалгааг ашиглан дүн шинжилгээ хийх замаар хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлт:

Зорилгод хүрэх байдал: Тогтоолын төслийн тогтоох хэсэгт 1 дэх заалтад “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар батлах ба 2 дахь заалтад Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих “Цагаан алт” хөдөлгөөнийг өрнүүлж, дараах арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгахыг заасан ба 3 дахь заалтаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн санхүүжилтийг "Цагаан алт" хөдөлгөөний хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээтэй уялдуулан ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгож, 4 дэх заалтаар тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг жил бүрийн хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлж, хэрэгжилт, үр дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд тус тус даалгасан нь тогтоолын төслийн үзэл баримтлалаар тавьсан зорилгыг биелүүлэх боломжтой гэж үзлээ.

Ойлгомжтой байдал: Тогтоолын төсөл нь тогтоолын гарчиг, тэмдэглэх хэсэг, тогтоох хэсэг гэсэн бүтэцтэй байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна. Тогтоолын төслийн тусгасан байдал нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 35, 36 дугаар зүйлд нийцсэн байна. Гэхдээ уг тогтоолын төслийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах нийт зардал 631.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай байна. Дээрх зардлын тооцоонд өөрчлөлт гарах үндэслэлтэй бөгөөд улсын төсөв, гадаадын зээл тусламжийн эх үүсвэрээс хамтран хэрэгжүүлэх боломжтой ажлууд байгаа тул нийт зардлын тооцоо өөрчлөгдөхөөр тусгах нь зүйтэй гэж үзэж байна. Түүнчлэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэх, ялангуяа 2024 онд нэн шаардлагатай байгаа 62.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх гэсэн заалтын 2024 он гэснийг дахин харах нь зүйтэй байна. Учир нь энэхүү үнэлгээг хийж буй хугацаагаар тооцоход энэхүү заалтын хэрэгжилт хангагдах боломж бага байгааг анхаарах мөн тогтоолын төсөлд хэд хэдэн тоог тогтоосон байгааг дахин нягтлах нь зүйтэй байна.

Харилцан уялдаа: Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төсөл нь зүйл заалт хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн зохицуулалт агуулаагүй, хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Зөвлөмж:

Энэхүү Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу холбогдох судалгаа хийгдсэн тул энэхүү судалгааны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн тогтоолын төсөл нь зорилгодоо хүрэх боломжтой, тогтоолын төслийг дагаж мөрдөхөд ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байх тул батлуулах боломжтой гэж үзэж байна.

---oOo---